

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-42
1. “Эрдэнэс Монгол” ХХК болон “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн танилцуулга мэдээлэл сонсох	6-25
2. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан Оюу толгой төслийн санхүүжилтийн хүүгийн зохистой байдлыг хянан үзэх, өөрчлөх асуудлаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг сонсох	25-32
3. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан Стратегийн ач холбогдол бүхий Оюу толгойн бүлэг ордын талбайн хил зааг дотор ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг "Онтрэ" компанийн хувьцааны төрийн эзэмших хувь, хэмжээг Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох талаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, холбогдох бусад асуудлыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг сонсох	32-42

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы Хянан шалгах түр хороо /Оюу Толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх/-ны 9 дүгээр сарын 24-ний өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга О.Батнайрамдал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 38 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Баярбаатар.

Хянан шалгах түр хорооны дарга О.Батнайрамдал “Шинжээч чөлөөлөх тухай”, “Шинжээч томилох тухай”, “Хянан шалгах түр хорооны хянан шалгагч, шинжээчийн ажлын хөлсний хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын түр хорооны тогтоолын төслүүд буюу хэлэлцэх асуудлын дарааллын 1, 2, 3 дахь асуудлуудыг хаалттай явуулах горимын санал гаргав.

Горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

О.Батнайрамдал: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 1

Бүгд: 6

83.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуралдааныг 11 цаг 40 минутад хаалттай горимд шилжүүлэв.

Нээлттэй хуралдаан 1 цаг үргэлжилж, 12 цаг 40 минутад эхлэв.

Нэг. “Эрдэнэс Монгол” ХХК болон “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн танилцуулга мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Ганхүү, мөн компанийн Ерөнхий менежер Б.Батбаатар, Геологи, уул уурхайн хэлтсийн менежер Л.Өнөрбаатар, Санхүү, шинжилгээний хэлтсийн менежер Б.Баяр-Өлзий, Хуулийн хэлтсийн менежер Ж.Наранпүрэв, Монгол талын ТУЗ-ийн гишүүн Н.Цэрэнбат, Э.Баясгалан, Э.Мэндтүвшин, Аж

үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн газрын Уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Б.Хулан, Ашигт матмал, газрын тосны газрын Хайгуул, ашиглалтын газрын Уул уурхайн хэлтсийн дарга Т.Зууннаст, мөн хэлтсийн Судалгаа, мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн Ц.Цэгц, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, мөн хэлтсийн мэргэжилтэн Б.Гарамханд, Ч.Нандинтуяа, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Чанар, бүтээмж хариуцсан менежер Д.Ядамжав, мөн компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Л.Наранчимэг, мөн газрын ахлах мэргэжилтэн Б.Цэлмэгтуяа, Геологи, үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга Ц.Төгсбуян, Геологи, хайгуулын зөвлөлийн зохицуулагч Л.Баярмандал, “Эрдэнэс Монгол” нэгдлийн Хууль, эрх зүйн зөвлөлийн зохицуулагч Б.Гэрлээ, Төслийн үнэлгээний хэлтсийн менежер Ү.Чулуунбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг, мөн газрын референт Д.Мөнхтуяа, ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн, Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн мэдээллийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Чанар, бүтээмж хариуцсан менежер Д.Ядамжав хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, С.Зулпхар нарын тавьсан асуултад “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн Санхүү, шинжилгээний хэлтсийн менежер Б.Баяр-Өлзий, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Чанар, бүтээмж хариуцсан менежер Д.Ядамжав, “Эрдэнэс Монгол” нэгдлийн Хууль, эрх зүйн зөвлөлийн зохицуулагч Б.Гэрлээ, Төслийн үнэлгээний хэлтсийн менежер Ү.Чулуунбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд “Эрдэнэс Монгол” ХХК-ийн болон “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн мэдээллийг сонслоо.

Уг асуудлыг 13 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан Оюу Толгой төслийн санхүүжилтийн хүүгийн зохистой байдлыг хянан үзэх, өөрчлөх асуудлаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Ганхүү, мөн компанийн Ерөнхий менежер Б.Батбаатар, Геологи, уул уурхайн хэлтсийн менежер Л.Өнөрбаатар, Санхүү, шинжилгээний хэлтсийн менежер Б.Баяр-Өлзий, Хуулийн хэлтсийн менежер Ж.Наранпүрэв, Монгол талын ТУЗ-ийн гишүүн Н.Цэрэнбат, Э.Баясгалан, Э.Мэндтүвшин, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн газрын Уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Б.Хулан, Ашигт матмал, газрын тосны газрын Хайгуул, ашиглалтын газрын Уул уурхайн хэлтсийн дарга Т.Зууннаст, мөн хэлтсийн Судалгаа, мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн Ц.Цэгц, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, мөн хэлтсийн мэргэжилтэн Б.Гарамханд, Ч.Нандинтуяа,

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Чанар, бүтээмж хариуцсан менежер Д.Ядамжав, мөн компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Л.Наранчимэг, мөн газрын ахлах мэргэжилтэн Б.Цэлмэгтуяа, Геологи, уйлдвэрлэлийн бодлогын газрын дарга Ц.Төгсбуян, Геологи, хайгуулын зөвлөлийн зохицуулагч Л.Баярмандал, “Эрдэнэс Монгол” нэгдлийн Хууль, эрх зүйн зөвлөлийн зохицуулагч Б.Гэрлээ, Төслийн үнэлгээний хэлтсийн менежер Ү.Чулуунбаатар нар оролцов

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг, мөн газрын референт Д.Мөнхтуяа, ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн, Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Ажлын хэсгийн мэдээллийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Амарбаясгалан хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, С.Зулпхар, Э.Болормаа, Ш.Бямбасүрэн нарын тавьсан асуултад Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Амарбаясгалан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан Оюу толгой төслийн санхүүжилтийн хүүгийн зохистой байдлыг хянан үзэх, өөрчлөх асуудлаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг сонслоо.

Уг асуудлыг 14 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан Стратегийн ач холбогдол бүхий Оюу толгойн бүлэг ордын талбайн хил зааг дотор ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг "Онтрэ" компанийн хувьцааны төрийн эзэмших хувь, хэмжээг Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох талаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, холбогдох бусад асуудлыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Ганхүү, мөн компанийн Ерөнхий менежер Б.Батбаатар, Геологи, уул уурхайн хэлтсийн менежер Л.Өнөрбаатар, Санхүү, шинжилгээний хэлтсийн менежер Б.Баяр-Өлзий, Хуулийн хэлтсийн менежер Ж.Наранпүрэв, Монгол талын ТУЗ-ийн гишүүн Н.Цэрэнбат, Э.Баясгалан, Э.Мэндтүвшин, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн газрын Уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Б.Хулан, Ашигт матмал, газрын тосны газрын Хайгуул, ашиглалтын газрын Уул уурхайн хэлтсийн дарга Т.Зууннаст, мөн хэлтсийн Судалгаа, мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн Ц.Цэгц, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, мөн хэлтсийн мэргэжилтэн Б.Гарамханд, Ч.Нандинтуяа, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Чанар, бүтээмж хариуцсан менежер Д.Ядамжав, мөн компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Л.Наранчимэг, мөн

газрын ахлах мэргэжилтэн Б.Цэлмэгтуяа, Геологи, уйлдвэрлэлийн бодлогын газрын дарга Ц.Төгсбуян, Геологи, хайгуулын зөвлөлийн зохицуулагч Л.Баярмандал, “Эрдэнэс Монгол” нэгдлийн Хууль, эрх зүйн зөвлөлийн зохицуулагч Б.Гэрлээ, Төслийн үнэлгээний хэлтсийн менежер Ү.Чулуунбаатар нар оролцов

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг, мөн газрын референт Д.Мөнхтуяа, ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн, Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Ажлын хэсгийн мэдээллийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, С.Зулпхар, Э.Болормаа нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан Стратегийн ач холбогдол бүхий Оюу Толгой бүлэг ордын талбайн хил зааг дотор ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг "Онтрэ" компанийн хувьцааны төрийн эзэмших хувь, хэмжээг Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох талаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, холбогдох бусад асуудлыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг сонслоо.

Уг асуудлыг 14 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Хянан шалгах түр хорооны нээлттэй хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 2 цаг 07 минут үргэлжилж, 11 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 90.9 хувийн ирцтэйгээр 14 цаг 45 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

О.БАТНАЙРАМДАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХЯНАН
ШАЛГАХ ТҮР ХОРОО /ОЮУ ТОЛГОЙ БҮЛЭГ ОРДЫН АШИГЛАЛТАД МОНГОЛ
УЛСЫН ЭРХ АШГИЙГ ХАНГУУЛАХ, ХҮРТЭХ ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХТЭЙ
ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧИГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ/
НЫ 9 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

О.Батнайрамдал: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Оюу Толгой бүлэг ордын ашиглалтын асуудлаарх Хянан шалгах түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул 2025 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийн ирцийг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Сархадын Зулпхар, Даваахүүгийн Пүрэвдаваа, Энхбатын Болормаа, Өлзийхүүгийн Шижир, Отгоншарын Батнайрамдал. Ирц 54.5 хувьтайгаар хуралдаан ийнхүү эхэлж байна. Өнөөдрийн хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ.

Үүнд:

Нэгдүгээрт, шинжээчийг чөлөөлөх тухай тогтоолын төсөл.

Хоёрдугаарт, Шинжээчийг томилох тухай тогтоолын төсөл.

Гуравдугаарт, Хянан шалгах түр хорооны хянан шалгагч, шинжээчийн ажлын хөлсний хэмжээг тогтоох тухай тогтоолын төсөл.

Дөрөвдүгээрт, Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан стратегийн ач холбогдол бүхий Оюу Толгой бүлэг ордын талбайн хил зааг доторх ашигт малтмалын ашигласны тусгай зөвшөөрөл эзэмшдэг Онтрэ компанийн хувьцааны төрийн эзэмших хувь хэмжээг Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох талаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, холбогдох асуудлыг сонсох, Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг сонсоно.

Тавдугаарт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан Оюу Толгой төслийн санхүүжилтийн хүүгийн зохистой байдлыг хянан үзэх өөрчлөх асуудлаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээр хийж санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг сонсоно.

Зургаадугаарт, Эрдэнэс Монгол болон Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн танилцуулга мэдээллийг сонсоно.

Хэлэлцэх асуудлаар өөр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх Түр хорооны шинжээчийг чөлөөлөх, томилох, цалин хөлсний асуудал нь түр хорооны дотоод асуудал бөгөөд Хянан шалгах түр хорооноос томилогдон ажиллахад шинжээч нарт хөндлөнгөөс нөлөөлөх магадлалтай учраас тус тогтоолын төслүүдийг хэлэлцэх хаалттай хуралдааны горимын саналыг гаргаж байна. Тэгэхээр эхний шинжээч чөлөөлөх, томилох, ажлын хөлсний хэмжээтэй холбоотой асуудлуудыг хаалттай горимоор, үлдсэн асуудлуудыг бүгдийг нээлттэй горимоор хэлэлцүүлэх ийм саналтай байна. Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг үндэслэн хуралдааныг түр хаалттай горимд шилжүүлэх горимын саналаар санал хураалт явуулъя аа.

Гишүүд санал хураалтад бэлдье.

Санал хураалт.

Гишүүдийн 83.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ. Хуралдааныг хаалттай горимд шилжүүлнэ үү.

О.Батнайрамдал: Эрдэнэс Монгол компани, Эрдэнэс Оюу Толгой компанийн мэдээллийг сонсьё. Ажлын хэсгийн гишүүдийг оруулъя. Тэр хооронд гишүүддээ нэг зар тараая. Швейцарын холбооны улсаас тухайн тэдний парламентын Хянан шалгах түр хороо болон ажлын албанаас өнөөдөр үдээс хойш 2 цаг 30 минутаас уулзалт байгаа. Тэгээд тэнд бид бүхэн оролцох боломжтой. Тэгээд мөн маргааш оройн хоол оройн зоог барихад 3 гишүүн оролцох боломжтой байгаа юм байна лээ.

Тэгэхээр нэг ёсондоо Швейцарт энэ Хянан шалгах түр хороо энэ ажилд бас яаж явдаг парламентын хяналт шалгалтын механизм хэрхэн ажилладаг талаар туршлага хуваалцах боломж байгаа юм байна лээ шүү манай гишүүд. Ажлын хэсгийн гишүүд Эрдэнэс Монголоос хүмүүс байна уу? Эрдэнэс Монгол ХК-ийн ерөнхий захирал байна уу? Өнөөдөр ирсэн юм биш үү? Хамт явсан хүмүүс нь ирчихсэн байх юм. Дамдинням сайд эд нартай хамтдаа явсан хүмүүс мөн биз дээ мөн үү? Дамдин сайд ирчихсэн байгаа шүү дээ. Эрдэнэс Монголын ерөнхий захирлыг дуудъя.

Өнөөдөр Эрдэнэс Монголтой холбоотой асуудлууд яригдахаар байгаа. Эрдэнэс Монголоос ирсэн ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя. Захирал нь байхгүй байна. Захирлын дараагийн албан тушаалд хэн билээ Ядамжав чанар бүтээмж хариуцсан менежер. Урагшаагаа микрофон руугаа сууна. Наранчимэг Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга урагшаагаа микрофон руугаа. Төгсбуян Геологи үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга. Баярмандал Геологи хайгуулын зөвлөлийн зохицуулагч, Амарбаясгалан Стратеги хэрэгжилт бизнес хөгжлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Цэлмэгтуяа Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн.

Эрдэнэс Оюу Толгойгоос ирсэн үү? Тэгээд төслийн үнэлгээний хэлтсийн менежер Чулуунбаатар баахан мэргэжилтэн менежер л явуулсан байна. Ерөнхий захирал хаана байгаа юм. Ерөнхий захирлаа дуудъя. Ажлын хэсэг явсан. Өнөөдөр ирчихсэн байгаа. Дамдинням сайд өнөөдөр чуулганы танхимд чуулганы хуралдаандаа оролцсон шүү дээ. Хамт явсан хүмүүс бүгдээрээ ирсэн. Тэгээд сайд дарга нар нь ирэх хэрэгтэй. Оюу Толгой ХК-ийн Монголын талын ТУЗ-ийн гишүүн Цэрэнбат, Баясгалан, Мэндтүвшин ирсэн байна.

Эрдэнэс Оюу Толгой Гүйцэтгэх захирал Ганхүү, ерөнхий менежер Батбаатар, Геологи уул уурхайн хэлтсийн менежер Өнөрбаатар, Санхүү шинжилгээний хэлтсийн менежер Баяр-Өлзий, Хуулийн хэлтсийн менежер Наранпүрэв.

Урагшаа микрофонд Эрдэнэс Монголоос хүмүүс сууцгаая. Эрдэнэс Монголоос Ядамжав менежер, Наранчимэг Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга байна уу? Наран Наранчимэг дарга хаана байна? Өвчтэй. Яг Улсын Их Хурал дээр асуугдах болохоор ингээд өвчтэй. Өөр асуудлаа яг мэдэх нь хүн нь урагшаа сууж байгаа. Ажлын хэсэгт яг орсон асуудлаа мэдэх хүн нь урагшаа сууж байгаа. Мэргэжилтэн ч хамаагүй бүр болохгүй бол Эрдэнэс Монголоос хэн суух юм? Эрдэнэс Оюу Толгой болон Оюу Толгойн ТУЗ-ийн гишүүдээс бид нар нэлээн мэдээлэл ажлын хэсэг авсан байгаа. Энэ удаа Эрдэнэс Монгол өнөөдөр танилцуулгаа хийх ёстой байгаа.

Эрдэнэс Монгол дээр бол бидний авсан нотлох баримтын хүрээнд бол Засгийн газрын тогтоолоор Засгийн газрын тэмдэглэлээр мөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын тушаалаар нэлээн олон ажлын хэсэг гарсан гэж ойлгож байгаа. Эрдэнэс Монголын гүйцэтгэх захирал Наранцогт захирлаар ахлуулсан ажлын хэсэг ер нь бол түрүү жилийн 10 сараас хойш Засгийн газраас чиглэлтэй юм байна шүү дээ тиймээ? Зээлийн хүү бууруулах болон Онтрэ дээр шийдэл гаргаж, яриа хэлэлцээрийг эхлүүлэх ажлын хэсгийг тухай бүрд нь Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг хүлээсэн юм байна. Бараг жилийн өмнөөс эхлээд.

Тэгэхээр энэ жилийн хугацаанд юу хийсэн бэ? Ямар арга хэмжээ авсан, юу хийсэн, өнөөдрийн шийдэл чинь юу вэ гэдгээ та бүхэнд танилцуулах хэрэгтэй байгаа.

Наранцогт захирал эрх хооронд хэн танилцуулах вэ? Эрдэнэс Монгол. 3 номерын микрофон. Өөрийгөө танилцуулъя. 20 минут байгаа. 20 минутад маш товчхон яг ямар ажлын хэсэг гарсан, хэдэн удаа хуралдсан, яг ямар арга хэмжээ авсан, ямар шийдэлтэй байгаагаа гишүүдэд маш тодорхой 20 минутад багтааж 15-аас 20 минутад багтааж танилцуулъя.

Дараа нь гишүүдэд асуулт асуух боломж олгох ёстой байгаа. 3 номерын микрофон. Өөрийгөө танилцуулаад эхэлье.

Д.Ядамжав: Сайн байцгаана уу? Түр хорооны дарга, гишүүд, ажлын хэсгийн бүрэлдэхүүн та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая аа. Эрдэнэс Монгол компанийн чанар бүтээмжийн менежер Ядамжав.

Наранцогт захирал Солонгост томилолттой ажиллаж байгаа учраас хүрэлцэн ирэх боломжгүй байгааг бас хүлцэл өчье.

Эрдэнэс Монгол компанийн зүгээс хийж хэрэгжүүлсэн ажлын талаар товч танилцуулгыг та бүхэндээ хүргэе.

Оюу Толгойн бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ өнөөгийн нөхцөл байдал.

Ерөнхийдөө 2 агуулгын хүрээнд ярихаар бэлдэж ирсэн.

Нэгдүгээрт, Жавхлант, Шивээ толгой ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох хүрээнд, 2 дугаарт хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүгийн түвшнийг нийцүүлэн бууруулах хүрээнд гэсэн 2 агуулгаар ярина аа.

Нэгдүгээр агуулгын хүрээнд бол түүхэн замнал, бүлэг ордын нөөц, олборлох төлөвлөгөө, хууль зүйн дүгнэлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, боломжит хувилбарууд, цаашдын төлөвлөгөөний талаар та бүхэндээ товч мэдээлэл өгье өө. Онтрэ компанийн эзэмшиж байгаа лицензүүдийн талбай түүхэн замналын хувьд бол дэлгэц дээр харагдаж байна 1958-аас 1995 онд бол ЗХУ болон Монгол Улсын геологичид анхлан зэсийн илрэлийг тогтоосон.

О.Батнайрамдал: Түүхэн замнал эд нарыг алгасчихъя. Эд нарыг бид нар Эрдэнэс ОТ-оос хангалттай сонссон. Та нар яг шийдэл чинь юу юм бэ? Яг авч хэрэгжүүлсэн арга хэмжээгээ л шууд ярья. Тэгэхгүй бол бид нарт хугацаа бага байгаа.

Д.Ядамжав: Яг Онтрэ компанийн богинохон наадхаа эд нар ч бараг лицензтэй талбайн зураглалыг та бүхэн харж харж байна танилцуулсан байх гэж бодож байна. Онтрэ компанийн эзэмшиж буй лицензийн талбай Оюу Толгойн бүлэг ордын нөөцийн хувьд бол Оюу Толгой компанийн нийт нөөцийн 2 хувьтай тэнцэх хэсэгт олборлолт эхлүүлэхээр одоогоор төлөвлөж байгаа Онтрэ компанитай холбоотой асуудал яригдаж байгаа.

Бусад хэсгийг бол 2038, 2073 оноос олборлох төлөвлөгөөтэй ингэж ажиллаж байгаа. Онтрэ компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц оролцоог танилцуулсан байгаа. Нийтдээ нийт хувьцааны 16.5 хувийг бол Рио Тинто компани бол эзэмшдэг. Хөрөнгө оруулалтын гэрээнд туссан байдал дээр бидний зүгээс хууль зүйн дүгнэлт хийсэн. 2009 онд байгуулагдсан Хөрөнгө оруулалтын гэрээгээр бол Онтрэ компани нь хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээрийн тал биш. Онтрэ компанийн ашиглалтын тусгай зөвшөөрлүүд, хөрөнгө оруулалтын гэрээний үйлчлэх хүрээнд хамаарахгүй. Онтрэ компанийн лицензүүдийг Хөрөнгө оруулалтын гэрээний үйлчлэл нь харилцан тохиролцсоноор бол хамруулах боломжтой гэсэн ийм саналуудыг бол гаргасан байгаа.

Оюу Толгой хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээрийн тал биш тул шинээр хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж, үр өгөөжийн дийлэнхийг Монгол Улсын Засгийн газарт ноогдох нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай гэж бол бид үзэж байгаа. Хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийх хүрээнд Эрдэнэс Монгол компаниас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөө, хийсэн ажлыг та бүхэнд танилцуулъя.

2025 оны эхний 9 сарын байдлаар бол бид бүхэн дараах ажлуудыг хийж ажиллаж байна. Өмнөх гэрээ хэлэлцээг судалж дүгнэлт боловсруулсан. Оюу Толгойн санхүүгийн загварчлалыг нягтлах дүн шинжилгээ хийж байгаа. ТЭЗҮ-ийн нийцэл уялдаатай байдлыг шалгаж байна. Санхүүгийн загварчлалын тооцоололт үндэслэн суурь өгөгдлийг бэлтгэсэн. Онтрэ Ресурс лимитэд компанийн хөрөнгө оруулагчдад зориулсан тоо баримттай харьцуулж дүн шинжилгээ хийгдэж байна. Санхүүгийн үндсэн загварчлалыг хөгжүүлж ажиллаж байгаа, санхүүгийн тооцоололд өгөөж тооцох тохируулгуудыг тусгасан. Өнөөгийн нөхцөл байдалд хууль зүйн дүгнэлт боловсруулж ингэж ажиллаж байгаа. Хөрөнгө оруулагчтай

хэлэлцээ хийх хүрээнд суурь өгөгдөлд хийсэн дүн шинжилгээг та бүхэнд танилцуулъя гэж бодож байна. ТЭЗҮ-ийн тодотгол болон Оюу Толгойн мөнгөн урсгалын загварчлалд манай компанийн санхүүгийн болон үнэлгээний холбогдох мэргэжилтнүүд дүн шинжилгээ хийж ажиллаж байгаа. Энэ хүрээнд бол зарим татварын хувь хэмжээг хуульд зааснаас өөрөөр тооцсон, хуримтлагдсан алдагдлыг таамаглалгүйгээс ноогдол ашиг хуваарилахад хугацаа зөрөөтэй байгаа.

Зарим татварын зардлыг капиталжуулаагүй орхигдуулсан. Санхүү байдлын тайлангийн таамаглалгүй үүнээс үүдэн санхүүжилтийн дутагдал, таамаглахад хүндрэлтэй ажлын капиталын таамаглалыг загварчлаагүй шилжүүлэн тооцох алдагдлын тооцоолол байхгүй сценар шинжилгээ хийх боломжгүй гэсэн алдаа дутагдлууд бол гарсан. ТЭЗҮ мөнгөн урсгалын загварт л дүн шинжилгээ хийж алдаатай тооцоолол, засварлах асуудлуудыг бол тодорхойлж ингэж ажиллаж байна аа.

Мөн Эрдэнэс Монгол компанийн зүгээс хийж хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийх хүрээнд хийгдэж байгаа ажлуудыг танилцуулъя. Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хувьд татварын хувь хэмжээг хуульд нийцүүлэн тооцсон. Хуримтлагдсан алдагдлыг таамаглалд тусгасан. Холбогдох татварын зардлыг капиталжуулсан. Санхүү байдлын тайлангийн таамаглалыг тусгасан. Ажлын нягтлалын таамаглалыг загварчилсан. Шилжүүлсэнд тооцох алдагдлын тооцооллыг тусгасан. Сценари шинжилгээ хийх боломжтой гэж ингэж үзэж байгаа. Тэгээд энэ дээр бол яах вэ манай санхүүгийн нарийн тооцоолол хийсэн хүмүүс эксел файл нээгээд ажиллаж байгаа. Та бүхэн тодруулж асуух бол боломжтой.

Санхүүгийн загварчлалыг боловсруулах ажлын явц бол нийтдээ 90 орчим хувьтай явж байгаа. Бид бүхэн дотооддоо олон улсын фаст стандартын дагуу загварчлалыг сайжруулж боловсруулж ажиллаж байна аа.

Хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийх хүрээнд Эрдэнэс Монгол компани боловсруулсан тооцооллын хувилбаруудыг та бүхэнд танилцуулъя.

3 хувилбарыг бол урьдчилсан байдлаар бид бүхэн хийсэн байгаа.

Үр өгөөжийн дийлэнх нь Үндсэн хуулийн 6.2-т заасны дагуу Монголын талд ноогдох шаардлагад нийцүүлэн энэхүү тооцооллыг боловсруулсан.

Хувьцаа эзэмшил, тусгай АМНАТ, суурь АМНАТ, үр өгөөжийн бүрэлдэхүүн давуу тал, сул тал гэдгийг бол тооцсон байгаа. 34 хувь буюу энгийн хувьцааны хүрээнд тусгай АМНАТ-аар орлуулах хувилбар байж болно. Энэ 2-ын хосолсон хувилбараар бас хэрэгжүүлэх боломжтой гэж ингэж үзсэн байгаа. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2026 оны 1 дүгээр улиралд буюу 2026 оны 3 дугаар сар хүртэлх хүрээнд бид нар дараах ажлуудыг хийж хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Зарим ажлууд бол хийгдээд явж байгаа. санхүүгийн загварчлалын тооцооллыг эцэслэнэ. Ажлын хэсэгт тооцооллыг танилцуулж чиглэлийг тусгана. Хэлэлцээрт баримтлах үндсэн зарчмаа батлуулах, хэлэлцээ хийх үе шат, алхмыг тодорхойлох. Хэлэлцээрт дэмжлэг үзүүлэх зорилго бүхий зөвлөх үйлчилгээний хуулийн баг авах, хөрөнгө оруулагчтай гэрээний гол нөхцөлөөр тохиролцох, хөрөнгө оруулалтын гэрээний төслийг боловсруулж хэлэлцээ хийх. Хөрөнгө оруулалтын

гэрээний төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, Улсын Их Хуралд танилцуулж шийдвэрлүүлэх, хөрөнгө оруулалтын гэрээг үзэглэх.

2026 оны 1 дүгээр улиралдаа багтаан Онтрэ компанитай хөрөнгө оруулалтын гэрээг байгуулахаар төлөвлөөд ажиллаж байна аа.

Хоёр дахь асуудал буюу хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүгийн түвшнийг зах зээлийн зарчимд нийцүүлэн бууруулах хүрээнд бол дараах агуулгаар та бүхэнд мэдээлэл өгье. Гэрээний зохицуулалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байгаа. Хүү бууруулах боломж, санал, дүгнэлт гэсэн энэ хүрээнд мэдээлэл өгье.

Хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах чиглэлээр гэрээнд туссан зохицуулалтын тухай та бүхэн мэдэж байгаа. Нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээ бол 2011 онд байгуулагдсан. 2018 онд Рио Тинто талаас зээлийн хүүг бууруулахгүй гэх байр суурийг илэрхийлж байсан. Өнөөдрийн хувьд бол ажлын хэсэг хэлэлцээрийн бэлтгэл ажлаа хангаад ажиллаж байгаа. 7 жил тутам санхүүжилтийн хүүгийн хувь болон энэхүү гэрээнд заасан хувь нийлүүлэгчдийн одоогийн зээлийн тодорхойлолт буй хүүгийн хувийг зохистой байдлыг хянан үзэх боломжтой гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Тэгээд энэ хүрээнд бол бид бүхэн ажиллаж байна. Одоогийн хувь хэмжээ бол лайбер + 6.5 гэсэн одоогийн юугаар бол софер 6.5 гэсэн ийм хүрээнд явж байгаа.

Хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах чиглэлээр 2018 оны ажлын хэсгийн хийж хэрэгжүүлсэн ажлуудыг бид бүхэн судалж нэлээн татаж харсан. Өмнөх хэлэлцээрийн үед яагаад зарим зүйл дээр бүтэлгүйтсэн, юун дээр анхаарах вэ гэдэг байдлаар 2018 оны ажлын хэсгээс хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг та бүхэнд мэдээлэл өгье гэж бодож байна.

2018 онд бол ЗГХЭГ-ын даргын тушаалаар бол 7 хүний бүрэлдэхүүнтэй судалгааны баг гарч ингэж ажиллаж байсан. Судалгааны баг бол олон улсын зөвлөх хэрэмтэй хамтран судалгаа тооцооллыг боловсруулж Рио Тинто талтай 4 удаагийн хэлэлцээрийг хийсэн байдаг. Олон улсын зөвлөх компаниар ажилласан тооцоолол, судалгаа, дүгнэлт боловсруулсан. Рио Тинто талтай хэлэлцээр хийсэн холбогдох ажлуудыг дэлгэцэн дээр харуулсан байна.

Хэлэлцээний явцад бол хөрөнгө оруулагч талтай тохирсон санал нийлээгүй асуудлуудыг энд та бүхэнд мэдээлэл өгөх үүднээс бэлтгэсэн байгаа. Хэлэлцээнд чухал ач холбогдолтой дараах хэлэлцээний зарчмуудыг бол хөрөнгө оруулагч талаас бол Монголын талаас хөрөнгө оруулагч талтай тохиролцож ажиллаж байсан юм байна лээ. Зээлийн хүүг тооцохдоо олон улсад хэрэглэгддэг кредит модель загварыг бол ашиглахаар бол 2 тал энэ дээр санал нэгдэж байсан. Хүүгийн хувь хэмжээг тооцохдоо сунгасан гарын зарчим буюу зах зээлийнхээ зарчимд нийцсэн байдлаар бол хувь хэмжээг тооцъё гэдэг дээр бол санал нэгдсэн байдаг. Төслийн санхүүжилтийн зээл буюу гуравдагч этгээдийн зээлийг хувь нийлүүлэгчдийн зээлтэй харьцуулан үзэхгүй байх зарчмыг тохирсон. Хувь нийлүүлэгчдийн зээл нь хамаарал бүхий этгээдүүдийн хэлцэл болохыг бол хөрөнгө оруулагч талаас бол энийгээ хүлээн зөвшөөрсөн байдаг юм байна лээ.

Дараах нөхцөлүүд дээр бол ойлголтын зөрүүтэй нэгдсэн байр суурьд хүрч чадаагүй.

Үүнд бол Оюу Толгой компанийн зээлжих зэрэглэлд хөрөнгө оруулагч талаас үзүүлэх шууд бус дэмжлэг имплесит саппортын нөлөөллийн хүүгийн хувь хэмжээг тодорхойлоход оруулж тооцох эсэх дээр бол санал нэгдээгүй. Зээлийн хүүгийн хугацааг хэрхэн тооцох вэ? Хэдэн жилийн хугацаатай байх вэ гэдэг дээр бол талууд эсрэг байр суурьтай байсан юм байна лээ. Энэ хүрээнд хэлэлцээний явцад хөрөнгө оруулагчтай чухал ач холбогдолтой асуудлууд дээр бол хэлэлцээний үндсэн зарчмуудаа бол уг нь тохирч байсан ийм зүйл байдаг юм байна лээ.

Хэлэлцээний үр дүнгийн тухайд Монголын талаас тооцоолол судалгаа олон улсын зөвлөх байгууллагын саналд үндэслэн хэлэлцээг зохион байгуулж ирсэн. Тэгээд хувь нийлүүлэгчдийн зээлийн лайбер нэмэх нь 6.5 хүүг лайбер нэмэх нь 3.2-4.5-ын хооронд болгож бууруулах тооцоолол саналтай байна гэсэн саналыг бол манай талаас илэрхийлж байсан. Хөрөнгө оруулагчдын зүгээс бол хувь нийлүүлэгчийн зээлийн хүүг лайбер нэмэх нь 8 хүртэлх хувиар өсгөх саналтай байна гэсэн. Бүүр ийм эсрэг саналыг илэрхийлж байсан. Хэлэлцээ бүрд нэг хүндрэлтэй зүйл байсан нь хөрөнгө оруулагчдын төлөөлөл өөрчлөгдөж байсан учраас албан ёсны итгэмжлэл бүхий этгээдийг томилж өгөхийг бол манай талаас бол хүсэж байсан. Албан ёсны хэлэлцээр хийх итгэмжлэлтэй эрх бүхий этгээдийг бол хөрөнгө оруулагч талаас томилохгүй. Уулзалт болгон дээр өөр хүмүүс томилж байсан нь бол хэлэлцээрийг бол хүндрэлтэй болгож байсан юм байна лээ.

Зээлийн хүүг бууруулах асуудлаар ажил хэрэгч байх тодорхой санал ирүүлэхийг бол бид хөрөнгө оруулагч талаас хүссэн. Рио талаас бол Засгийн газрын зүгээс баталгаа гаргах нөхцөлд бид бүхэн зээлийн хүүг бууруулах боломжтой юм гэсэн ийм зөрүүтэй саналыг илэрхийлж байсан. Товчоор хэлэх юм бол хөрөнгө оруулагч талаас бол тодорхой идэвх чармайлт гаргаагүй ийм байдалтай байсан гэж үзэж болохоор байгаа. Оюу Толгой төслийн үнэ зээлийн өнөөгийн нөхцөл байдал, эргэн төлөлт, хүүгийн түвшний тухайд манай компанийн зүгээс тодорхой мэдээлэл судалгаа хийсэн байгаа.

Өнөөдрийн байдлаар бол 2025 оны 6 сарын 30-ны байдлаар Оюу Толгой төслийн зээлийн нийт үлдэгдэл бол яах вэ хувь нийлүүлэгчдийн зээлийн өр бол нэг 11.9 тэрбум ам.доллар. Энэ нь бол нийтдээ өнөөдрийн ханшаар софер 6.7 буюу 11.3 хувийн хүүтэй зээлийн хүү бол ийм өндөр байгаа. Эргэн төлөгдөх хугацаа бол 2037 он гэж үзэж байгаа. Төслийн санхүүжилт, урьдчилгаа төлбөрийн гэрээ, спонсорын давуу эрхтэй зээл, эргэлтийн хөрөнгийн зээл гэх мэт. Энэ зээлийн зээлийн хүү эргэн төлөгдөх хугацааг бол дэлгэц дээр та бүхэнд харуулж байна.

Аж үйлдвэр Эрдэс баялгийн сайдын А 29 дүгээр тушаалаар яг энэ хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах асуудлаар 2025 оны 2 сарын 11-ний өдрөөс ажлын хэсэг байгуулагдаж, дэд ажлын хэсэг байгуулагдаж ингэж ажилласан. Ажлын хэсгийн даргаар бол Эрдэнэс Монгол компанийн захирал Наранцогт, ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар Дотоод хяналт эрсдэлийн удирдлагын газрын дарга Наранчимэг дарга ажилласан. Наранчимэг даргын тухайд нурууны хагалгаанд орсон хэвтрийн дэглэмтэй байгаа учраас өнөөдөр хүрэлцэн ирж амжаагүй. Тэгээд онлайнаар оролцох боломж олговол би оролцоход бэлэн гээд хүлцэл өчсөн байгаа.

Энэ хүрээнд бол 4 чиглэлээр үүрэг өгөгдсөн эхнийх нь буюу Оюу Толгой компанийн хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах чиглэлээр бол тодорхой ажлуудыг голчилж танилцуулъя гэж бодож байна. Нөгөө 3 ажил бол Улсын Их Хурлын 103 дугаар тогтоолтой холбоотой. Тэгэхдээ энэ хүрээнд бол холбогдох

ажлын хэсгүүд дээр бол ажлууд нь хийгдсэн байгаа. Ажлын хэсгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, энэ оны эхний 9 сарын байдлаар дараах ажлуудыг бол хийгээд явж байна. Ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж батлуулсан хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах хэлэлцээг эхлүүлэх тухай албан ёсны мэдэгдлийг бол хөрөнгө оруулагч талд хүргүүлсэн хариу ирсэн байгаа.

Оюу Толгой компанийн хувьд нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах шинэчлэх асуудлаар олон улсад нэр хүнд бүхий зөвлөх үйлчилгээ авах ажлын даалгаврыг боловсруулж ажлын хэсгээр хэлэлцэж баталсан. Оюу Толгой компанийн 2024 оны санхүүгийн тайланд шинжилгээ хийж ажилласан байгаа. Оюу Толгой компанийн зээлийн эргэн төлөлтийн хуваарьт шинжилгээ хийсэн. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад ажлын хэсгийн тайлангаа бол бид хүргүүлээд ингээд ажиллаж байгаа.

Ажлын хэсэг байгуулж өгөх хүсэлтийг Засгийн газарт уламжилсан. Нөгөө шинэ Засгийн газар байгуулагдсантай холбоотойгоор процесс өмнөх ажлын хэсэг маань хүчингүй болоод шинээр ажлууд хийгдээд явж байгаа. Рио Тинто талтай техникийн уулзалтыг хийсэн. Зээлийн хүүгийн тооцооллыг дотооддоо хийж ажиллаж байгаа. Ер нь хөрөнгө оруулагч талтай яриа хэлэлцээр хийх бэлтгэл ажлыг бол хангаад ажиллаж байгаа гэж үзэж болно оо.

2018 оны ажлын хэсэгт бол хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах хүрээнд бол дараах саналуудыг гаргаж ажиллаж байсан юм байна лээ. Рио Тинто компанид хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг 3.24 хувь байхаар санал болгож хэлэлцээг бол хийж ажиллаж байсан. Ер нь бол зах зээлийн зарчимдаа буюу сунгасан гарын зарчмаар бол бид нар хэлэлцээгээ хийнэ гээд дараах 6 агуулгын хүрээнд бол ажлууд хийгдэж байсан. Монголын талаас зээлжих зэрэглэлүүдийнхээ саналыг өргүүлсэн. Рио Тинто талаас зөрөөтэй байсан зүйлүүд байсан. Хүснэгт дээр та бүхэн харж байгаа байх. Өнөөдрийн бидний хийж байгаа тооцооллоор зээлийн хүүг бууруулах боломжит тооцоолол зээлжих зэрэглэлээс хамаарч ийм байдлаар дотооддоо дүгнэлт гаргаж ажиллаж байгаа.

Зээлжих зэрэглэл, хугацаа, тайлбарын тухайд В нэмэх зэрэглэлээр 66-аас 8 жилийн хугацаатай байх юм бол энэ бол Монгол Улсын Засгийн газрын бондын үнэлгээ байгаа. Софер бол 3.4 хувьтай, +3.4 байж болох. Би зэрэглэлээр 6-аас 8 жилийн тухайд софер нэмэх 4.2, В -6- 8 жил гэхэд софер нэмэх 4.5 гэсэн ийм байж болохоор хувилбарууд дэвшүүлсэн байгаа. Одоогийн нөхцөл бол софер 6.5 байгаа гэдгийг та бүхэн мэдэж байгаа. 2018 оны ажлын хэсгийн аргачлалд суурилан, тооцооллыг шинэчлэн гүйцэтгэхэд зээлийн хүүг 2-оос 3 нэгжээр бууруулах боломжтой гэж урьдчилсан тооцоолол хийсэн. Үр дүнгийн хувьд бол мөн төстэй байна гэж ингэж үзэж байгаа. Бидний хийсэн тооцооллоор хүлээгдэж буй үр дүнг бол зээлийн хүүг бууруулснаар Монгол Улсын хүртэх өгөөжид бол эергээр нөлөөлнө гэж ингэж үзэж байгаа.

Хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг 3 нэгжээр бууруулахад Монгол Улсын Засгийн газарт ноогдох өгөөж 2 тэрбум ам.доллараар нэмэгдэх тооцоололтой байгаа. Нийтдээ ТЭЗҮ 2023 онд хийгдсэн хувь нийлүүлэгчийн зээлийн хүүг 3 хувь бууруулах, хувь нийлүүлэгчийн зээлийн хүүг 3.5 хувь руу хувиар бууруулах гэсэн хүрээнд бол Монголын талд өсгөх өгөөж 11.9 тэрбум ам.доллар буюу нийт ашгийн 37 хувь, 3 байхад бол 44 хувь, 3.5 хувиар бууруулсан тохиолдолд 45 хувь байхаар гэсэн ийм санал төсөөллийг боловсруулж ажиллаж байгаа.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд олон улсын зөвлөх үйлчилгээ үзүүлэгч байгууллагаар тооцооллыг нягталж хийсэн тооцооллоо баталгаажуулах шаардлага байгаа. Зөвлөх үйлчилгээ авах эх үүсвэрийг Эрдэнэс Монгол компанийн ТУЗ-ийн 2025 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд Эрдэнэс Оюу Толгой компанид бол эх үүсвэрийг баталж өгсөн. Ингээд ажиллаж байгаа. Ажлын хэсгийн судалгаа тооцооллыг олон улсын зөвлөхөөр баталгаажуулж хэлэлцээр хийх. Ерөнхий сайдын 67 дугаар захирамж Сангийн сайдын 169 дүгээр захирамжаар ажлын хэсгүүд гараад ингээд ажиллаж байгаа.

Ажлын хэсгийн судалгаа тооцооллыг олон улсын зөвлөхөөр баталгаажуулж хэлэлцээг үр дүнд хүргэх ажил бол одоогоор хүлээгдэж байна гэж ингэж үзэж байна. Санал, дүгнэлт хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүгийн зохистой түвшнийг олон улсын зөвлөхтэй хамтран өнөөдрийг хүртэл ажлын хэсгүүдээр хийсэн тооцоо судалгааг баталгаажуулан хэлэлцээрийг үр дүнд хүргэж ашиглах шаардлагатай байгаа. Нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээний зээлийн хүүг хянан үзэх зохицуулалтыг бодитоор хэрэгждэг аль нэг талын эрх ашигт нийцсэн бус зах зээлийн шударга зарчмыг мөрддөг хэлбэрт шилжүүлэх тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулах шаардлага үүсэж болзошгүй тул гэрээнд өөрчлөлт оруулах суурь шалтгааныг засах асуудлаар Улсын Их Хурлын Хянан шалгах хорооны дүгнэлт гаргавал бидний ажилд дэмтэй гэсэн ийм саналтай байгаа.

Ингээд анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа. Нарийн тодорхой асуултуудыг манай холбогдох мэргэжилтэн менежерүүд хариулах боломжтой.

О.Батнайрамдал: Наранцогт захирал ирж байна гэнэ үү. Монголд ерөөсөө байхгүй байгаа юм уу? Хамт явсан хүмүүс нь ирчихсэн байна шүү дээ. Дамдинням сайд ирчихсэн Засгийн газрын хуралдаа ороод сая чуулганд ороод.

Тэгэхээр нэг асуулгаадахаач. Наранцогт сайд Монголд ирсэн байгаа юм уу үгүй юм уу. Өнөөдөр аягүй чухал асуудал яригдаад байна л даа. Энэ чинь Оюу Толгой ярьж байгаа шүү дээ. Оюу Толгой ярьж байхад та нарын байж байгаа царай яг ийм л байна шүү дээ. Захирал нь байхгүй. Ажлын хэсгийн нарийн бичиг нь хаана байгаа юм тэгээд. Нарийн бичиг нь байхгүй.

Та нарын презентаци чинь 2018 онд Засгийн газрын хийж байсан үйл явцыг л тайлбарлачихлаа шүү дээ. Яг өөрсдөө юм хийсэн юм уу? Би гишүүддээ бас мэдээлэл өгөөдөхье. Монгол Улсын надаа миний гарт Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл байна. Эрдэнэс Оюу Толгой компанитай холбоотой асуудлаар Засгийн газраас өгсөн чиглэлүүд байна л даа.

Энэ дээр энэ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 сарын 30-ны өдрийн хуралдааны 38 дугаар тэмдэглэл. Одоогоос нэг ёсондоо яг жилийн өмнө Монгол Улсын Засгийн газраас та нарт үүрэг өгч байжээ. Манай Хянан шалгах түр хорооны 2 үндсэн сэдвээр хөндөнө. Олон чиглэл байна. Бусад чиглэлийг нь би орхилоо. Яагаад гэвэл манай хүрээ хязгаараас давчхаж.

Нэгдүгээрт, Оюу Толгой ХК-ийн хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах шинэчлэх асуудлаар яриа хэлэлцээр хийж гэж байна шүү. Яриа хэлэлцээр хийх ажлын хэсгийг байгуулж, бэлтгэл ажлыг хангаж яриа хэлцлийг эхлүүлнэ гэж байна. Нэг ёсондоо та нарт өгсөн Засгийн газраас өгсөн үүрэг бэлтгэл ажлаа хангаад яриа

хэлэлцээрийг эхлүүлээд үр дүнг нь тухай бүрд нь танилцуулахыг Эрдэнэс Монголд даалгажээ. Эрдэнэс Монголд даалгасан байна.

Зээлийн хүүг бууруулах бүх бэлтгэл ажлаа хангаад яриа хэлэлцээрээ эхлүүлээд үр дүнгээ Засгийн газарт тухай бүрд нь танилцуул гэсэн байна. Энэний гүйцэтгэлийг асууж байгаа юм. 1 дүгээрт.

Хоёрдугаарт Онтрэтэй холбоотой 2 ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайгаас Монголын талын хүртэх өгөөж, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр дагавар эрсдэлийн тооцоог боловсруулж, 2024 оны 12 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эрдэнэс Монголд үүрэг болгож байна. Нэг ёсондоо 2024 оны 12 сар буюу 9 сарын өмнө та нар Онтрэгийн энэ эрсдэлийн тооцоолол эдийн засагт үзүүлэх үр дагавар, өгөөжийг тооцоолоод 12 сардаа багтаж түрүү жилийн 12 сард Засгийн газрын хуралдаанд танилцуулах ёстой байсан байна. Тэгэхээр энэ 2 дээр асуудал яриад байгаа юм л даа. Тэгэхээр яагаад гэвэл танай дээр үүрэг нь өгөгдсөн байна. Яагаад гэвэл Эрдэнэс Монголд Эрдэнэс Оюу Толгой дамжиж Оюу Толгойн Монголын эзэмших хувь Эрдэнэс Монголд харьяалагддаг тиймээ?

Тэгэхээр Засгийн газраас чиглэл өгөнгүүт Туваан сайдаар ахлуулсан дэд ажлын хэсэг гарсан гэж ойлголоо. А 29 дүгээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын тушаал миний гарт байна л даа. А 29 дүгээр тогтоол. А 29 дүгээр тушаал яг энэ зээлийн асуудал дээр зээлийн хүүг бууруулах шинэчлэх асуудлаар яриа хэлэлцээр хийхийг Эрдэнэс Монгол компанийн гүйцэтгэх захирал Наранцогтоор ахлуулсан ажлын хэсэг 2 сарын 11-нд гаргасан. 2025 оны 2 сарын 10 одоогоос 7 сарын өмнө энэ зээлийн хүүгээ бууруулаад энэ дээр яриа хэлэлцээрээ эхлүүлээч гэсэн ажлын хэсэг гарсан байна.

Тийм учраас би нарийн бичгийн дарга нарыг нь бүгдийг нь дуудсан юм. Яг энэ ажлын хэсгийн. Эрдэнэс Монгол ХК-ийн Дотоод хяналт эрсдэлийн удирдлагын газрын дарга Наранчимэг нарийн бичиг хаана байна аа? Эрдэнэс Оюу Толгой ХК-ийн Санхүү шинжилгээний хэлтсийн менежер Баяр-Өлзий байна уу? Баяр-Өлзий урагшаа суучих. Яг ярих нь микрофон дээрээ сууя, ярихгүй нь хойшоо суу. Би точный асуулт асууя. Эхлээд ямар ч байсан эхлээд асуултаа асуучихъя.

Энэ Наранцогт захирлаар ахлуулсан энэ ажлын хэсэг зээлийн хүүг бууруулаад шинэчлэх асуудлаар яриа хэлэлцээр хийх энэ ажлын хэсэг 2 сард буюу 7 сарын өмнө байгуулагдаад хэдэн удаа хуралдсан бэ? Сая та нарын презентацийг харах юм бол 2018 оны Засгийн газрын тухайн үеийн хийсэн ажлыг л тайлагначихсан байна шүү дээ. Өөрсдийн хийсэн юм байна уу? Хэдэн удаа хуралдсан юм? Хэдэн удаа хуралдаж ямар үр дүн одоогоор гарсан байгаа вэ? 7 сарын хугацаа өнгөрсөн байна. Яагаад энийг хэлээд байна вэ гэхээр бид нар энэ зээлийн хүүг бууруулах хугацаа энэ оны төгсгөлөөр дуусах гээд байна шүү дээ. Та нарт 100 гаруй хоног л үлдсэн байна. 100 гаруй хоног үлдсэн байна.

Тэгэхээр үлдсэн 265 хоногтоо ямар яриа хэлэлцээр хийж, ямар үр дүнд хүрсэн юм бэ? Тэрийгээ өнөөдөр ажлын хэсэг дээр ирж энэ Хянан шалгах түр хорооны гишүүддээ тайлагна гээд байгаа юм л даа. 5 номерын микрофон.

Б.Баяр-Өлзий: Сайн байцгаана уу? Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн Санхүү шинжилгээний хэлтсийн менежер Баяр-Өлзий. А 29-ийн нарийн бичиг. Тэгээд А 29-ийн ажлын хэсэг байгуулагдсанаас хойш бүрэн бүрэлдэхүүнээрээ 3 удаа хуралдсан.

Багийн жижиг хурлууд болохоор 4-өөс 6 удаа хуралдсан байгаа. Тэгээд хурлаар гарсан үр дүн гэх юм бол хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах асуудал дээр болохоор ажлын даалгаврыг батлуулсан, холбогдох судалгаануудыг хийсэн, тэгээд эх үүсвэрийг баталсан байгаа.

Онтрэтэй холбоотой асуудал болохлоор А 29 дээр бол ажлын чиг үүрэгт нь байхгүй.

О.Батнайрамдал: Зээлийн хүүтэй холбоотой 2 сарын 11-нд одоогоос 7 сарын өмнө. 7-оос илүү байна л даа. 7 сар 10 хоногийн өмнө байгуулагдсан ажлын хэсэг дээр энэ зээлийн хүүг бууруулах чиглэл Засгийн газраас та бүхэнд аль жилийн өмнө ирсэн юм байна шүү дээ. Бүүр түрүү жил. Түрүү жилийн 10 сард Монгол Улсын Засгийн газраас та бүхэнд зээлийн хүүг бууруулах яриа хэлэлцээрийг эхлүүлэе эцэслэ гэдэг чиглэл өгсөн байна тэ? Тэгээд ажлын хэсэг байгуулагдаад 3 удаа хуралдсан. 3 удаа хуралдаад сая юу гэсэн бэ? Юуны ажлын даалгавар баталсан юм. Ямар судалгаа хийсэн юм? Яриа хэлэлцээр эхэлсэн үү? Ямар үр дүн гарсан юм? 5 номерын гишүүн дахин хариулъя. Нарийн бичгийн дарга.

Б.Баяр-Өлзий: Хувь нийлүүлэгчийн зээлийн хүүгийн зохистой түвшнийг тогтоох санхүүгийн зөвлөх үйлчилгээ авах ажлын даалгаврыг боловсруулсан. Тэрийгээ хурлаараа баталсан байгаа.

О.Батнайрамдал: Ажлын даалгавар баталсан гэдэг нь 7 сарын хугацаанд нэг ажлын даалгавар гадаад зөвлөх юм уу, дотоод юм уу? Гадаад зөвлөх авах ажлын даалгавар л баталсан юм уу? Зөвлөхөө авсан уу?

Б.Баяр-Өлзий: Зөвлөхөө аваагүй аваагүй тендер зарлагдсан уу? Тендер зарлагдаагүй байгаа. Эх үүсвэр нь болохлоор 2025 оны 8 сарын 5-ны Эрдэнэс Монголын ТУЗ-ийн хурлаар батлагдсан.

О.Батнайрамдал: Тэр 7 сарын хугацаанд ажлын даалгавар л хийсэн юм уу, ажлын даалгавар хийж баталсан юм уу?

Б.Баяр-Өлзий: Холбогдох судалгаануудыг бүгдийг нь хийсэн. Яг ОТ дээр эх үүсвэрийн бүтцийн хувьд ямар асуудлууд байгаа, ашигт ажиллагаанд хэрхэн яаж нөлөөлж байгаа, ирээдүйд яаж нөлөөлөх, үнийн дарамтыг бууруулахын тулд ямар ямар арга хэмжээ авч болох вэ гэдэг дээр судалгаануудыг дотооддоо хийсэн. Яг ажлын хэсэг дээр.

О.Батнайрамдал: Тэр судалгаа яагаад танилцуулагдахгүй байгаа юм тэгээд. Сая та нарын презентац дээр бол 2018 оны тухайн үеийн Засгийн газрын хийсэн ажлын үр дүнг л тайлбарлаад байна шүү дээ. Та нар өөрсдөө энэ 7 сарын хугацаанд яг ямар судалгаа хийсэн юм. 3 удаа ажлын хэсэг л хуралдсан юм байна шүү дээ. Энэ чинь хэдэн тэрбум долларын асуудал ярьж байгаа шүү дээ. Энэ асуудал цаашаагаа ингэж гал авч явсаар байгаад Улсын Их Хурал дээр Хянан шалгах түр хороо хүртэл байгуулагдчихаад явж байна шүү дээ.

Парламентын 126 гишүүний 89 гишүүн буюу парламентын нийт гишүүдийн 70 хувь дэмжээд Хянан шалгах түр хороо энэ зээлийн хүүг бууруулах дээр хүртэл байгуулагдаад өнөөдөр та бүхэнд хэлэлцээрт ороод эцэслэхэд зуухан хоног үлдсэн байна шүү дээ. Тэгэхээр энэ 7 сарын туршид та нар хэлэлцээрээ хийхгүй тэгээд

зөвхөн нэг ажлын даалгавар батлаад л нэг төсөв батлаад л ийм л түвшинтэй явна. Үр дүнгээ тэгээд Засгийн газарт танилцуулсан юм уу? Харьяалагдах сайдуудаа танилцуулсан уу? Харьяалагдах сайдууд нь мэдэж байгаа юу? Хариулах хүн байна уу?

5 номерын микрофон.

Б.Баяр-Өлзий: Сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан Сангийн сайдаар ахлуулсан ажлын хэсэгт холбогдох тайлан мэдээллээ хүргүүлчихсэн байгаа. Аж үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. Тэгээд Хянан шалгах түр хорооны нотлох баримтад хүргүүлчихсэн байгаа. Холбогдох бүх материалуудыг.

О.Батнайрамдал: Яг л эндээс айж байсан байхгүй юу. Юу ч хийгдээгүй байх вий дээ. Олон тэрбум долларын асуудал яригдаж байгаа. Би бас нэг асуусан. Эрдэнэс Монгол компанийн хамгийн танай охин компаниудын харьяа компаниудын хамгийн том компани. Монголын эдийн засагт хамгийн нөлөөтэй компани нь юу вэ? 3 номерын микрофон. Бүтээмж хариуцсан менежер хариулна уу.

Ү.Чулуунбаатар: Эрдэнэс Оюу Толгой компани Оюу Толгой төслийн тухайд бол Монголын эдийн засагт шууд болон дам өгөөжийн хувьд хамгийн том нөлөөтэй байгаа яг улсын эдийн засагт ачаа үүрч байгаагийн хувьд бол Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэт үйлдвэр, Монголросцветмет гэсэн компаниуд гадаад валютын нөөц эдийн засгийн гол ачааллыг үүрч ажиллаж байгаа.

О.Батнайрамдал: Та хэллээ. Монголд байгаа Эрдэнэс Оюу Толгой буюу Оюу Толгой төслийг Монголын эзэмшил бол ач холбогдлоороо хамгийн том. Ачаа үүрч байгаа нь ондоо компаниуд байна? Тэгээд энэ урвуу хамаарлаа тэгээд та нар янзлахгүй юм уу? Та нарт Засгийн газраас чиглэлийг нь өгчихсөн юм байна шүү дээ. Энэ дээр тэгээд нэг гаднын зөвлөх авна гээд л нэг ажлын даалгавар л 7 сарын туршид баталсан. Яагаад энэ дээр яг юу ч хийгдээгүй юм бэ гэдгээ яг бид Хянан шалгах түр хорооны гишүүдийн өмнө яг тайлбарлаадхаач. Яг юу хориод байсан юм. Юу болохгүй байсан юм? Яагаад гуравхан удаа хуралдсан юм? Яагаад одоо хүртэл энэ Засгийн газрын тэмдэглэл дээрээ яриа хэлэлцээрт орж эцэслэх гэсэн үг үсэг байгаад байна шүү дээ. Энд тэндээс эсвэл битгий хий гэсэн чиглэлтэй юм уу? Одоо нээлттэй ярих хэрэгтэй. Яагаад хийгдээгүй юм бэ гэдэг энэ энгийн асуултад хариул гээд байна шүү дээ. 3 номерын микрофон.

Д.Ядамжав: Ажлын хэсгийн зүгээс тодорхой ажлуудыг өнгөрсөн хугацаанд хийж хэрэгжүүлсэн. Оюу Толгой компани хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах шинэчлэх асуудлаар ажлын даалгаврыг бол боловсруулж ажлын хэсгээрээ хэлэлцэж баталсан. Оюу Толгой компанийн 2024 оны санхүүгийн тайланд бол дүн шинжилгээ хийгдчихсэн байгаа. Оюу Толгой компанийн зээлийн эргэн төлөлтийн хуваарьт мөн шинжилгээ хийгдсэн. Манай дээр дэлгэрүүлж хариулбал боломжтой. Мөн хийгдсэн ажлуудаа бас холбогдох дэлгэрэнгүй байдлаар Сангийн яам болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд бол хүргэж ажилласан. Нөгөө талд бол хэлэлцээ хийх мэдэгдлээ хүргүүлсэн, хариу ирсэн. Бэлтгэл ажлууд хангагдаад явж байгаа.

О.Батнайрамдал: Үгүй харин таны хариулт чинь ингээд л ингэсэн тэгсэн тэгээд үнэнийг хэлэхэд ажлын даалгавраас өөр юм батлаагүй л юм байна шүү дээ.

Яриа хэлэлцээрт ор гээд байна шүү дээ. Яриа хэлэлцээрт ерөөсөө ороогүй юм байна тийм үү?

Д.Ядамжав: Техникийн уулзалт хийгдсэн байгаа. 8 сард.

О.Батнайрамдал: Техникийн уулзалт гэж юу юм? Тайлбарлаад яг техникийн уулзалтад хаана, хаанаас яг орсон юм? Яг юу юм техникийн уулзалт гэж.

5 номерын микрофон.

Б.Баяр-Өлзий: 2 удаа техникийн уулзалт хийсэн. ОТ ХХК-ийн төлөөлөл болон Рио Тинтогийн төлөөлөл ээгээд Эрдэнэс Оюу Толгой болон Эрдэнэс Монголын төлөөлөлтэйгөөр хамтарсан уулзалт хийсэн. Ер нь хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах тал дээр ямар үе шатуудыг дамжаад хэрхэн хэлэлцээр хийх вэ гэдэг дээр 2 удаагийн уулзалт хийсэн.

О.Батнайрамдал: Ийм л юм байна. Тэгээд та нарын презентаци дээр зарим нь миний хийсэн слайд л явж байна л даа. Энд тэндээс хуулаад хэдэн слайд л тавьчихаж байна болиорой та нар. Жишээ нь миний хийсэн слайд тэндээс нь хуулаад авчихсан байна шүү дээ болж байгаа юм уу энэ чинь тэгээд.

Нэг иймэрхүү байдалтай уул нь танай компани өөрсдөө хэллээ шүү дээ. Манай хамгийн том компани нь Оюу Толгой. Оюу Оюу Толгойн Монголын хувьцаа эзэмшиж байгаа Эрдэнэс Оюу Толгой маань. Тэгээд энэ хамгийн том компани дээрээ тэгээд хамгийн их цагаа зарж байх ёстой юм биш шүү. Та нар чинь ТӨК-уд дотроосоо хамгийн өндөр цалинтай мундаг хүмүүс биз дээ? Тэгээд энэ презентаци чинь тэгээд яагаад тэгээд Онтрэгийн асуудал байхгүй байгаа юм? Онтрэд ОТ-гоос зээл өгдгийг мэдэх үү? Ямар хүүтэйг нь мэдэх үү? Одоогийн байгаа түвшнээс нэг 3 хувь л бууруулахад болно гэсэн ийм л гаргалгаатай сууж байгаа юм байна л даа. Наадах чинь шинэ юм биш. Наадах чинь 2018 онд Засгийн газрын тухайн үеийн Засгийн газрын ажлын хэсэг дээр гарсан шийдвэрийг зүгээр тэрийг нь хуулаад тавьчихсан байна шүү дээ.

Онтрэгийн гэрээ уншсан хүн байгаа юу энэ дотор? Онтрэ ОТ-той 2025 оны 2 сард гэрээ байгуулсан. Хамтын ажиллагааны гэрээ. Энэ дотроос Эрдэнэс Монголын ажлын хэсэг дотор байгаа уншсан хүн байна уу? Гараа өргө, тэгээд л харъя. Эрдэнэс Монголоос. Би асуултаа мэдэж байгаа. Би 56 хуудас гэрээ бүгдийг нь уншихсан байгаа шүү дээ. Тэрэн дээр хүүг хэд гэж тооцсон юм? Тэрэн дээрээ Монголын хөрөнгө оруулалтын гэрээтэй харьцуулахад ямар ямар хэмжүүрээр өөр өөр байгаа юм? Дүгнэлтээ хэлэх үү? 2 номерын микрофон. Өөрийгөө танилцуулаад.

Ү.Чулуунбаатар: Эрдэнэс Монгол компани төслийн үнэлгээний хэлтсийн менежер Чулуунбаатар байна. Хамтын ажиллагааны гэрээн дээр бол би яах вэ нэг удаа уншсан болохоор яг бүрэн сайн санахгүй л байна л даа. Энэ дээр зээлийн хүүгийн софер дээр нэмэх нь 3 хувь гээд ойролцоогоор 6-аас 7 хувь болж байсан гэж санаад байх юм. Энэ дээр яах вэ би нөгөө нэг таныг яг уншсан хүн байна уу гэхээр нь л яасан л даа. Тэрнээс биш яг бүрэн цээжилж харьцуулсан юм бол одоохондоо байхгүй байгаа. Бид хэд нөгөө санхүүгийн загварчлал боловсруулаад ажиллаж байгаа энэ дээр нөгөө ТЭЗҮ юмнуудыг ухаад.

О.Батнайрамдал: Харин санхүүгийн загварчлалын чинь үндсэн орц нь наадах чинь шүү дээ. Ийм л байдалтай байна даа. Онтрэд Оюу Толгой Монголын Засгийн газар Рио Тинто руугаа зээл өгөөд, 11.3 хувь тооцоод байна шүү дээ. Онтрэ гээд бидний асуудал болгоод байгаа компани руугаа хэдэн хувиар зээлж байгаагаа одоо хүртэл мэдэхгүй байна шүү дээ. Буруу хариулт. Наадах чинь Канад компани. Канадын Прайм буюу Канадын бодлогын хүүн дээр нэмэх нь 2 хувь гэж байгаа юм. Нэг ойролцоогоор л цээжилсэн юм шиг байгаа юм. Бодвол миний өгсөн ярилцлагаас л уншаа биз. Өнөөдрийн байдлаар, өнөөдрийн зах зээлийн ханшаар 6.7 байхгүй юу. 6.7 хувийг Оюу Толгой Онтрэ рүү гээд байхад чинь та нарын оруулж ирж байгаа хувилбар чинь софер дээр нэмэх нь 3.5 гэсэн үү тэ? Энүүнтэйгээ харьцуулж ядаж нэг дүгнэлт хийж чадахгүй юу? Та нарын презентаци дээр алга. Наад презентаци чинь 2018 оны тухайн үеийн Засгийн газрын хийсэн ажлыг л тавьчихсан байна.

Надаа өөр асуулт үнэндээ алга. Ийм л байдалтай байна. Танай хамгийн том компани Оюу Толгой гэгчихлээ. Тэгээд өнөөдөр Эрдэнэс Оюу Толгой дээрээ Засгийн газрын өгсөн чиглэлийнхээ дагуу ажлын даалгавраас өөр юм батлаагүй. Тэгээд 2 сард буюу сая тавхан сарын өмнө байгуулагдсан Монголын эдийн засагт хамгийн нөлөөтэй нэг том гэрээ байгуулагдсан. Онтрэтэй байгуулсан гэрээнийхээ хүүг нь мэдэхгүй байна шүү дээ. 56 хуудас гэрээ байгаа. Зүгээр гүүгдээд унш наадхаа. Онтрэгийн веб сайт руу ороод унш. Тэрийг мэдэхгүйгээр хэлэлцээрийн сонголтууд гаргана гэж байна. Битгий утгагүй юм ярьж бай. Юу ч хийгээгүй байна шүү дээ. Ийм байдалтай Оюу Толгой дээр харьцаж болохгүй байхгүй юу даа. Та нар Монгол улсын Засгийн газрыг төлөөлж ОТ-д хамаарч байгаа толгой компани мөн биз дээ? Өндөр цалинтай залуучууд. Та нарт 100 хүрэхгүй хоног үлдсэн. 7 сарын туршид та нарын хийсэн ажил сая өөрсдөө тайлбарлалаа.

Тэгээд нэмэлт асуултыг манай гишүүд асуу. Гишүүд нэрсээ өгөх үү? Асуулт асуух гишүүд нэрс өгье. Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Тодорхой асуултууд байна аа. Энэ Засгийн газрын хуралдаанаас тэмдэглэл гараад тэмдэглэлээр их тодорхой даалгаврууд өгчихсөн тэрнээс ямар үр дүн гарсан бэ гэдгийг л бид тодруулж асуух ёстой. Түр хорооны ажил нь юм чинь. Тэгээд зарим зүйл дээр хариулт байхгүй байгаа. Зарим зүйл нь яах вэ явц нь явж байгаа гэдэг нэг ийм ойлголттой л болж байх шиг байна л даа. Миний эхний асуулт та бүхэн сая хариулж байх шиг байна. Энэ Засгийн газрын тэмдэглэл дээр чинь ингэчихсэн байгаа шүү дээ Оюу Толгой ХК-ийн хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах, шинэчлэх асуудлаар яриа хэлэлцээ хийх ажлын хэсгийг байгуулж, бэлтгэл хангаж, яриа хэлэлцээг эхлүүлэн үр дүнг тухай бүр танилцуулахыг Эрдэнэс Монгол ХХК Наранцогт, Эрдэнэс Оюу Толгой ХХК Ганхүүд гээд ингээд үүрэг болгосон байгаа юм. Яг энэ дээр уншсанаар бол хэлэлцээг эхлүүлнэ гэгчихсэн байгаа юм. Тэгэхээр та бүхэн тэр нөгөө хийсэн уулзалтуудаа хэлэлцээгээ эхэлчихлээ гэж ойлгож байна гэж ойлголоо. Зөв үү? Ер нь яг хэлэлцээ тогтсон хугацаандаа дуусах уу? Тогтсон хугацаа гэдэг нь ийм байгаа шүү дээ. Бид энэ зээлийн хүүтэй холбоотой бидэнд 98 хоногийн хугацаа үлдчихсэн байна лээ. Өнөөдрөөс тооцох юм бол. Тэгэхээр 98 хоногийн хугацаанд багтааж бид энэ асуудлыг танай ажлын хэсэг эцэслээд Засгийн газартаа танилцуулаад тэгээд энэний үр дүн гарна гэж ойлгож болох уу ингэх боломжтой юу гэж байгаа юм.

Дараагийн асуулт энэ зээлийн хүүг бол бууруулахтай холбоотой тооцооллыг 2-оос 3 нэгжээр бууруулна гээд та бүхэн ийм тооцоолол танилцуулж байна. 2018 онд ч гэсэн нэг иймэрхүү тооцоолол байсан юм байна. 2 талаасаа ярьж байсан юм

байна гэж ойлголоо. Энэнээс илүү багаар бууруулах боломж бий юу гэсэн 2 дахь асуулт байна. Та бүхэнд өөр тооцоолол байгаа юу?

Саяын асуултын араас 3 дахь асуулт. Бидэнд өгөгдсөн мэдээллээр та бүхний урьдын өгсөн танилцуулгаар яаж байна гэхээр зэрэг энэ төсөл эхэлж байх үеийн Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, эдийн засаг, санхүүгийн байдал гээ. Өнөөдрийнхтэй харьцуулах юм бол дээрдсэн.

Хоёрдугаарт төслийн эрсдэл өөрөө асар багассан.

Гуравдугаарт бол яах вэ дэлхийн түүхий эдийн зах зээл дээр бол яг энэ Оюу Толгой төсвөөс гарч байгаа түүхий эдийн эрэлт хийгээд үнэ бол хангалттай өссөн. Цаашдаа бол энэ өсөх магадлалтай. Энэнээс аваад үзэх юм бол төсөл бараг эрсдэлгүй төсөл гэдэг нь ойлгомжтой.

Дөрөвдүгээрт төсөл бол үндсэндээ 99 хувийн гүйцэтгэлтэй. Тэр гүний уурхайг хэлж байна шүү дээ. Энэ үүднээс нь аваад үзэх юм бол зээлийн хүүг бол дан ганц манай нөгөө зээлжих зэрэглэлийн үнэлгээнээс гадна бусад шалгуураар бол тооцож болох юм шиг ийм тайлбарууд өгөөд байсан байхгүй юу. Тэр 3 дахь асуулт бол та бүхэн саяын хэлсэн уулзалтууд дээрээ эс үгүй бол хүргэсэн хүсэлт дээрээ эс үгүй бол та бүхний тооцоолол дээр саяын нөхцөл байдлуудыг тооцсон байдлаар тооцоолол хийж байгаа юу гэсэн ийм асуулт байгаа юм. Нэг минут нэмээд авъя.

О.Батнайрамдал: Зулпхар гишүүнд нэмэлт нэг минут.

С.Зулпхар: Дараагийн 4 дэх асуулт болохоор нэг ийм асуулт байгаад байна аа. Та бүхэн мэдээж хэрэг сайн тооцоолол хийж байгаа байх. Тэгээд өнгөрсөн бидний хуралдаанууд дээр танилцуулга ийм байсан байхгүй юу. Оюу Толгойн талаас Рио Тинто талаас юу гэж танилцуулдаг вэ гэхлээр зэрэг энэ төсөл дээр Монголын талын хүртэх үр өгөөж бол 53 хувь юм гээд ингээд танилцуулдаг. Бид өөрсдөө тооцохоор зэрэг манай 2023 оны ТЭЗҮ-ээр бол 37 хувьтай байна гээд бид өөрсдөө тооцдог ийм л ойлголттой болсон л доо. Тэгээд саяын зээлийн хүүг бууруулаад 2 янзаар ингээд тооцоолол хийхээр зэрэг хувь нийлүүлэгчийн зээлийн хүүг 3 хувиар тооцсон байна. 3.5-аар тооцсон байна. Тэгэхээр зэрэг Монголын талын хүртэх үр өгөөж 44 хувь, 45 хувь болж байгаа юм. Гэтэл нөгөө тал чинь бидэнд танилцуулахдаа та нар 53 хувийн өгөөж хүртэнэ гээд хэлчихсэн шүү дээ.

Тэгэхээр энүүгээр аваад үзэх юм бол 53, 45 хоёрын хооронд гээ л дээ. Манай талын максимум тооцооллоор нь. Энд чинь нэг тийм бараг 8 хувийн бидний үр өгөөж бол байхгүй харагдаад байна л даа. Тэгэхээр хэрвээ бид нар.

О.Батнайрамдал: Зулпхар гишүүн маш тодорхой точный асуулт асууж байна шүү яг тодорхой хариулна. Эрдэнэс Монголоос хариулъя. Эхлээд хэн хариулах юм? 2 номерын микрофон. Маш тодорхой хариулна.

Ү.Чулуунбаатар: Гишүүний асуултад хариулъя. Одоо бид нарын хийсэн тооцооллоор бол 2-оос 3 хувь бууруулах боломжтой гэж ингэж танилцуулсан. Гэхдээ энэ тооцоолол маань юун дээр суурилж байна вэ гэхлээр Оюу Толгойн зээлжих зэрэглэлийг бид нар урьдчилсан байдлаар тооцчихсон байгаа. Тэгэхээр бид нар олон улсын зөвлөх байгууллагатай хамтарч ажиллаад яг энэ Оюу Толгойн зээлжих зэрэглэлийг албан ёсоор тодорхойлоод ингээд зээлжих зэрэглэл маань

сайн гарах юм бол энэ 2-оос 3 хувиас ч илүү хувиар бууруулах боломж бүрэн байгаа. Нөгөө талаас мэдээж та бүхэнд таны саяын дурдсаны дагуу Оюу Толгой төслийн нөхцөл байдал харьцангуй сайжирсан.

Тухайлах юм бол Оюу Толгой төслийн хувьд 2023 оны ТЭЗҮ-ээр тухайн үед тооцож байсан ашигт малтмалын үнэ бол одоогоор зарим ашигт малтмалын хувьд 2 дахин ихэссэн. Зарим ашигт малтмал 20- 30 хувь өссөн ийм үзүүлэлттэй байгаа. Тэгэхээр энэ өнөөгийн зах зээлийн энэ үнэ ханшаар байх юм бол Оюу Толгой төсөл 31 он гэхэд зээлээ төлж дуусах ийм урьдчилсан тооцоолол бид нар гаргасан.

Тэгэхээр мэдээж энэ зах зээлийн нөхцөл байдал Оюу Толгой төслийн энэ бүтээн байгуулалт дуусаж байгаатай холбоотойгоор энэ нь өөрөө зээлжих зэрэглэлийг сайжруулаад ингэснээр илүү бага хүүг тогтоох бүрэн боломж байна гэж бид нар харж байгаа юм.

О.Батнайрамдал: Үлдсэн асуултад хариулахгүй юм уу? Үлдсэн 3 асуулт байна.

Ү.Чулуунбаатар: Би сая нөгөө 2 дахь, 3 дахь асуултад нэгтгээд ерөнхий байдлаар хариулсан байгаа.

О.Батнайрамдал: Эрдэнэс Монголоос Зулпхар гишүүний асуултад нэмж хариулах хүн байна уу? Юмаа мэдэх хүн байна уу? Бодож байгаарай хариулт авна. Тэр хооронд нэг зүйлийг хэлье.

Болгоомжтой ярихгүй 2-оос 3 хувиар л бууруулах ийм тооцоололтой гээд юун дээр үндэслэж 2-оос 3 хувь гэж яриад байна. Наадах чинь тийм амар зүгээр санаснаараа ярьдаг тоо биш шүү. Хэдэн тэрбум доллар ард нь яригдаж байгаа шүү дээ. Судалгаагүй тэгээд л энд тэнд уншсанаараа 2-оос 3 гэж ярьж болохгүй шүү. Би хэлээд байна шүү дээ. Онтрэ дээр өгсөн зээлийн хүү чинь хэд юм. Тэр чинь зээлжих зэрэглэл тогтоохгүйгээр тэгээд хийж болоод байхад яагаад та нар заавал зээлжих зэрэглэл хийлгэж байж Монголын түвшин тогтоно гэдэг ийм юм яриад байна. Нөгөө л нэг 2018 оны Засгийн газрын хийсэн ажлын дүгнэлтийг л үндэслээд байх шиг байна л даа? Тэр ажлын дүгнэлт өөр шүү. 2018 он 7 жилийн өмнө хийсэн ажлын дүгнэлтийг үндэслэж өнөөдөр дүгнэлт хийдэг чинь буруу шүү. Нэмж хариулт байна уу? Нэмж хариулах хүн байна уу? Эрдэнэс монголоос. Ажлаа мэдээд нэмж хариулах хүн алга уу?

Болохгүй бол Эрдэнэс ОТ-оос асууя. Эрдэнэс Оюу Толгой 5 номер Баяр-Өлзий менежер.

О.Батнайрамдал: Эрдэнэс Оюу Толгойн санхүүгийн шинжилгээний хэлтсийн менежер Баяр-Өлзий. Рио Тинто болон яг Монголын талын өгөөжийн зөрөө юун дээр гараад байна вэ гэхлээр аргачлалын зөрөө байгаад байгаа юм. Рио Тинто юу юуг өгөөжид оруулж тооцоод байгаа вэ гэхлээр 1 дүгээрт бэлтгэн нийлүүлэгчид төлсөн НӨАТ-ыг тооцож оруулж байгаа. Энэ яг төсөвт татвар байдлаар төлөхгүй байгаа. Энэ нь болохоор бэлтгэн нийлүүлэгчдэд гэрээний үнийн дүн дээрээ нэмж төлсөн НӨАТ-аа татварын орлого болгож нэмэгдүүлээд байгаа. Энэ нь буруу. Тэгээд зарим нэг татварыг яг олон улсын Дэлхийн банк болон бусад байгууллагуудын зөвлөмжийн дагуу өгөөжид оруулах ёсгүй байдаг. Жишээ нь НДШ болон ХХОАТ-ыг тухайн төслийн өгөөжид оруулж тооцохгүй байх ёстой.

Рио Тинтогийн зүгээс болохоор бүх төрлийн татвар төлбөр хураамж бүгдийг нь оруулж байгаа. Тэгээд төсөвт төлөхгүй байгаа НӨАТ-ын татварыг хүртэл оруулж байгаа.

Бас нэг асуудалтай зүйл нь болохоор EQT байдлаар оруулсан хөрөнгө оруулалтын зардлыг бүтэн хэмжээгээр нь хасаж байгаа. Тэрний 34 хувийг нь болохлоор Монголын хувьцааны Монголын талын 34 хувьд ноогдох хэмжээний хөрөнгө оруулалтаа Монголын тал өөрөө хийгээд тэр нь өр үүсээд явж байсан. Тэр нь бүрэн дүнгээрээ Рио Тинто компанийн өгөөжөөс хасагдах ёсгүй юм гэх мэтчилэн яг техникийн аргачлалын нарийн зөрөөнүүд нэлээдгүй байгаа. Яг Монголын талын тооцож байгаа аргачлал нь болохлоор бүгд тайлбарлах нотолгоотой. Ямар ч байсан шалтгаанууд нь бүгд тайлбарлагдахаар байгаа. Бид нар бол яг аль алийг өгөөжид тооцож болох вэ гэдгээ Баялгийн сангийн тухай хууль болон бусад заавар зөвлөмжүүдэд нийцүүлээд гаргаж байгаа юм. Тэгэхлээр уг төслөөс авч байгаа өгөөж маань бол анхны тохиролцсон нь өгөөжийн хувьд хүрэхгүй байгаад байгаа.

О.Батнайрамдал: Зулпхар гишүүн нэмэлт тодруулга.

С.Зулпхар: Баярлалаа. Зохих түвшний мэдээлэл өгч байна.

Гэхдээ энэ нэг зүйлийг тодруулъя. Өнгөрсөн ч гэсэн яг энэ зүйл яригдсан л даа. Аргачлал дээрээ тохирохгүй байна гээд. Тэгээд энэ тохирдог аргачлалын олон улсын жишиг гэж байна уу? Тэрийгээ 2 талаасаа саяын хэлэлцээрийн явцад энийг ярьдаггүй юм уу гэж ярих уу? Ер нь аргачлал гэдэг чинь хүн ойлгож чадахгүй эс үгүй бол тэрийг нь хэн нэгэн бодож болдоггүй зүйл биш байх. Илүү тодорхой байх ёстой. Тэгэхгүй болохоор зэрэг тухайн компани та нар 53 хувийн үр өгөөж хүртээд байна гээд байдаг. Бидний тооцооллоор бол одоо байгаа нь 37 л байгаа шүү дээ. Тэгээд бид энийгээ нэмэгдүүлэх гээд саяын хэлсэн тэр хүүгийн өөрчлөлтөөр бол сайндаа л 45 хувь болгож байна шүү дээ. Тэгэхээр энэ бол их дэндүү хариуцлагагүй ийм тооцоолол болчихоод байна гэсэн үг шүү дээ. Бидний хүлээлт бол нийцэхгүй байна гэсэн үг. Энэ чинь том төсөл байхаас гадна 2 талдаа харилцан ашигтай байх ёстой ийм зарчим өөрчлөх ёстой бол харилцан ашигтай биш байна гэсэн үг юм. Нөгөө нэг асуулт бол цагаа нэмээд авчих уу? Дарга энэ тодруулгадаа цаг хүрэхгүй байна аа.

О.Батнайрамдал: Зулпхар гишүүнд нэмэлт цаг.

С.Зулпхар: Гол зүйл бол одоо энэ хүүг жишээ нь тогтоохтой холбоотой зүйл дээр 2018 оны тэр үеийн хэлцлийн хэлэлцээрийн үед гарч ирсэн саналыг яагаад өнөөдөр ингээд дахин дахин тэрийгээ бид санал болгож байгаа юм шиг эсвэл ийм байж болохоор юм шиг та бүхэн танилцуулаад байгаа юм бол би ойлгохгүй байна л даа.

Та бүхний өмнөх танилцуулга дээр чинь бидний санхүү эдийн засгийн нөхцөл байдал тэр төслийн хувьд ч тэр. Монгол Улсын өөрийнх нь тухайд ч гэсэн дээр сайд ч гэсэн гэдэг ийм танилцуулга хийсэн шүү дээ. Тэр танилцуулгаар чинь л бид нар нөгөө асуухаар зэрэг та бүхний танилцуулж байгаа зүйл чинь тэрнийхээ эсрэг байгаад байгаа байхгүй юу. Хүүг бол тэрнээс илүү буулгах боломжтой гэж л орох байх. Нөгөө талд чинь бол 2018 онд юу гэсэн гэхээр зэрэг бид бүүр хүүг нь өсгөнө гэж ийм тактикой орж ирсэн байна лээ шүү дээ. Тэгээд ойлгомжтой тэр нөгөө тал

өсгөнө гэж хэлээд ядаж зогсооно гэж бодсон юм байгаа биз. Би зүгээр сайн мэдэхгүй байна л даа. Энэ зүйл дээр та бүхэн тайлбар хийгээч гэж байгаа юм.

О.Батнайрамдал: Маш тодорхой асуулт асууж байна. Хэн хариулах вэ? 2 номерын микрофон өөрийгөө танилцуул.

Ү.Чулуунбаатар: Эрдэнэс Монгол компанийн төслийн үнэлгээний хэлтсийн менежер Чулуунбаатар байна. Гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт энэ аргачлалаа тохирч болдоггүй юм уу гэж асууж байна. Энэ дээр болохоор яг суурь шалтгаан нь бол Хувь нийлүүлэгчдийн гэрээн дээр яг аргачлалыг нь тодорхойлж өгөөгүй, нарийн зохицуулаагүй. Аль нэг тал нь идэвх санаачилга гаргахгүй бол яах вэ гэдэг дээр ямар ч зохицуулалт байхгүй болохоор Рио Тинто талаас зүгээр л ингээд зээлийн хүүг чинь өсгөнө гэсэн тийм хариу бариад л ингээд хугацаа хождог ийм хүндрэл бэрхшээл бол бид нарт байгаа. Нөгөө талаасаа энэ бид нарын хийчихсэн байгаа тооцоолол 3 хүртэлх хувиар бууруулах боломж байна гэж байгаа юм. Энэ бол зүгээр урьдчилсан тооцоолол. Бид нар өөрсдийнхөө дотоод боломж дээр тулгуурлаад л 2018 оны ажлын хэсгийн олон улсын ашигласан аргачлал, нөгөө талдаа тохирсон энэ аргачлалаар тооцоод үзэхэд ийм байна гэж өөрсдийнхөө боломж дээр тулгуурлаад тооцоолол хийчихсэн байгаа. Мэдээж олон улсын зөвлөх бол энийг цааш нь баталгаажуулаад эцэслэн тогтоох байх.

О.Батнайрамдал: Нэмэлт хариулт хангалтгүй байна аа. Нэг юмаа л тойроод л яриад л байна л даа.

2018 оны ажлын хэсгийн дүгнэлтээ ярихаа боль та нар өөрсдөө дүгнэлт гаргаач. Юугаа хийж байгаа юм? 7 сар юугаа хийсэн юм бэ? 7 жилийн өмнөх Засгийн газрын ажлын хэсгийн дүгнэлтийг өнөөдөр яриад байгаа юм. Онигоо шүү. Зулпхар гишүүнд нэмэлт микрофон.

С.Зулпхар: Өнгөрсөн оны 10 сарын 30-ны өдрийн Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээс хойш байгуулагдсан л ажлын хэсэг л байна л даа. Жил орчим болох гэж байх шиг байна. Нэлээн ажиллаж л байгаа байх. Тэрийг айхтар үгүйсгэмээргүй байна. Гэхдээ нэг зүйлийг та бүхэнд хэлмээр байна л даа. Үнэхээрийн та нарын хийсэн тооцоолол бол саяын тооцоолол бидэнд хангалттай биш. Энийг нэгэнт нээлттэй явж байгаа юм чинь тийм хангалттай биш гэдгийг нээлттэй ярих нь зөв.

Хоёрдугаарт олон улсын нэг шинжээч аваад энэ дээр бол ахиад тооцоолол хийлгэнэ гэж байна шүү дээ. Энийг өнөөдөр хүртэл яагаад та нар хийлгэхгүй байгаа юм бэ? Энэ чинь угаасаа та нарын ажил байсан шүү дээ. 98 хоног үлдчихлээ. Бид хэзээдээ энийг авч тооцооллыг нь хийлгээд, хэзээ нөхдүүд нөгөө нөгөө нөхдүүдтэйгээ энэ хүүн дээрээ тохирох юм бэ? Энэ чинь хугацаа нь дөхчихлөө шүү дээ. Яах юм та чинь ингээд өөрсдөө.

О.Батнайрамдал: Зулпхар гишүүн маш ойлгомжтой хэлж байна шүү дээ. Зүгээр нэг гадаад хүн хийх юмыг чинь ингээд ажлын даалгаврыг нь бэлдсэн болоод 7 сар өнгөрчихсөн л байна л даа. Өөрсдөө та нар тэгээд юу хийж байгаа юм. Заавал нэг гаднын зөвлөх ажиллаж байж хийх юм уу та нар чадахгүй юм уу тэгвэл. Чадахгүй учраас гаднын зөвлөх авах нь зөв өө л гэж үзсэн юм байна гэж ойлголоо шүү. Тэгээд ингэсээр байгаад 7 сар алдаад. Одоо бид нарт сая Зулпхар гишүүн хэдэн хоног

гэлээ. 98 хоног үлдсэн гээд 98 хоногтоо тэгээд яах юм? Гадаад зөвлөхөө аваад тэр нь ажлаа хийгээд үр дүнг чинь өгөөд Засгийн газраар хэлэлцүүлээд тэгээд эцэслэх юм уу? 98 хоногтоо багтах юм уу? Өөрсдөө хийж чадахгүй юм уу? Тэгээд чадахгүй гэж үзэж байгаа юм уу? Тийм л дүгнэлтэд хүрч байна даа.

Пүрэвдаваа гишүүний микрофоныг өгье.

Д.Пүрэвдаваа: Бүгдээрэнд нь энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Ажлын хэсгийн мэдээлэлтэй танилцлаа. Тэгээд давхардуулж асуугаад яах вэ гэж ойлголоо. Би зарим зүйлийг тодруулж асуух нь зүйтэй байх гэж. Арбитраас гарсан шийдвэр лицензийг шилжүүлэх ёстой гэж ойлгосон зөв үү? Тэгэхээр лиценз шилжүүлэх шийдвэр гаргахын тулд Монголын татварын байгууллага миний ойлгосноос баталгаажаагүй тул гэдэг ийм үндэслэлээр ийм тодорхойгүй нөхцөл байдал үүсээд байна гэж ойлголоо. Тэгээд энэн дээр та бүхэн маань ямар хариуцлага хэн үүрэх ёстой юм? Яг хэний хариуцсан ажлыг аягүй тодорхой мэдээлэл авмаар байна? Тэгээд энэ Оюу Толгой компани яагаад энэ олон жил энэ татварынхаа асуудлыг Монгол Улсын мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжийн дагуу татварынхаа энэ тайлан мэдээг ирүүлдэггүйг та бүхэн маань ямар байдлаар тайлбарладаг юм гэдгийг бас асуумаар байна.

Тэгээд дараагийнх нь зүйл. Энэ хүүгийн асуудал ойлгомжтой. 7 жилдээ нэг удаа заавал ярих ёстой. Түрүүний хуралдаан даргалагч Батнайрамдал дарга маш ойлгомжтой хэлсэн. Онтрэ бол хүү нь өөрөөр бодогдож байгаа. Та бүхэн маань түрүүн маш алдаатай ярьсан. Оюу Толгой бол дэд компаниасаа маш өндөр хувиар зөвхөн тэр компанитай нөгөө гэрээ байгуулж мөнгө зээлэх тийм гэрээтэй гэж би ойлгосон. Тэрийгээ та бүхэн маань Монгол Улсын байр суурийг яагаад илэрхийлэхгүй байгаа юм бэ? Тэгээд дараагийнх нь нэг зүйл байна. Ер нь энэ танай компанийн эс үйлдлийг бид нар чинь ингээд жилдээ тооцох юм бол олон 100 сая долларыг алдаж байгаа шүү дээ. Тэгээд танай компанийн эс үйлдлийг бид нар одоо уул нь гэм хорыг тогтоож, тэгээд тэр алдсан боломжийг хохирлыг та бүхнээс нэхэмжлэх ёстой гэж хараад байгаа байхгүй юу. Улсын Их Хурлаар цаг хугацаанд нь оруулж ирэх ёстой мэдээллийг оруулж ирэхгүй байна.

Өөрсдийнхөө Монголын талаас хийх ёстой байсан арбитрын шийдвэрийг хэрэгжүүлэхгүй байгаа дээр та бүхэн маань ямар алхам хийсэн юм бэ гэж асууж байна аа.

Тэгээд тодруулна.

О.Батнайрамдал: Пүрэвдаваа гишүүн маш тодорхой асуулт асуулаа. Хариулт хэн өгөх вэ? Эрдэнэс Монгол. Эрдэнэс Монголоос хариулах хүн байна уу? Эрдэнэс Монголоос ахалж ирснээрээ Ядамжав хүртээмжийн менежер. 3 номерын микрофон. 3 номерын микрофон ямар ч байсан хариулъя. Та ахалж ирсэн байна. Наранцогт захирлаа орлож ирсэн байна.

Д.Ядамжав: Гишүүний асуулт саналыг ойлголоо. Тэгээд манайхаас Хууль, эрх зүйн зөвлөлийн менежер Гэрлээ хариулаад, Геологи үйлдвэрлэлийн бодлогын газраас нэмэлт тодруулга өгье өө.

О.Батнайрамдал: Хариулт байхгүй байна. 4 номерын микрофоныг өгье дөө. Өөрийгөө танилцуулаад хариултаа өгье.

Гэрэлээ: Эрдэнэс Монгол компанийн Хууль, эрх зүйн зөвлөлийн зохицуулагч Гэрлээ байна аа.

Арбитрын шийдвэр 2024 оны 12 сарын 19-нд гарсан. Онтрэ компанийн тусгай зөвшөөрлүүдийг шилжүүлэх гэсэн гэхдээ тухайн улсын хуулийн дагуу шилжүүлэх гэж байгаа. Тэгээд тэрэнтэй л холбогдуулаад ажиллагаа нь бол хийгдэж эхэлсэн байгаад байгаа. Татвар ашигт малтмалаас ажиллагаагаа хийгээд явж байгаа.

О.Батнайрамдал: Та бүхний дүгнэлтийг юу байна гэж Пүрэвдаваа гишүүн асуугаад байна шүү дээ. Тэгсэн чинь интернэт дээр байгаа юм уншаад байх юм. Хариулт байхгүй бол хариулт мэдэхгүй байна гээд хэлчих. Мэдэхгүй юм байна гэж ойлголоо. Ийм л байдалтай байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Дараагийн удаа захиралтайгаа шийдэлтэйгээ бүх зүйлтэйгээ ирэх хэрэгтэй. Танай компанийн чинь хамгийн том компани Эрдэнэс Оюу Толгой. Оюу Толгойн Монголын талын эзэмшил шүү.

Тэгэхээр тэрнийхээ асуудлаа хамгийн түрүүнд тавих ёстой шүү дээ тэ? Тэгэхээр энэ дотор мэдэж байгаа ч хүн алга. Асуултад ч хариулж чадахгүй тэгээд гишүүд гараад явчихлаа. Ингээд дуусгая. Ингээд Эрдэнэс Монгол компанийн мэдээлэлтэй танилцсанд тооцёё.

13.44 цаг

Дараагийн асуудал. Дарааллын дагуу дараагийн мэдээлэл танилцуулах асуудлыг танилцуулъя.

Монгол улсын ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан Оюу Толгой төслийн санхүүжилтийн хүүгийн зохистой байдлыг хянан үзэх өөрчлөх асуудлаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг Сангийн сайд Жавхлан танилцуулна.

Танилцуулгатай холбогдуулан хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя.

Сангийн сайд Жавхлан. Жавхлан сайд амжаагүй юм байна. Амарбаясгалан Санхүү бодлогын газрын Санхүүгийн зах зээл олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга. Амарбаясгалан дарга. Гарамханд Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн урагшаа суучих. Нандинтуяа Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн. Нандинтуяа микрофон руу урагшаага суучхаарай. Жавхлан сайд чөлөө авсан уу? Хүлээх боломжгүй л гэсэн байсан. 3 номер уу. 3 номер танилцуулгаа эхэлье.

Б.Амарбаясгалан: Сайн байцгаана уу? Хянан шалгах түр хорооны дарга болон гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Захирамжаар байгуулагдсан ажлын

хэсгийн нарийн бичиг нь байгаа. Өнөөдөр та бүхэндээ ажлын хэсгийн үйл явцыг танилцуулъя.

Оюу Толгой төслийн санхүүжилтийн хүүгийн зохистой байдлыг хянан үзэх өөрчлөх асуудлаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцэж, санал боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2025 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 67 дугаар захирамжаар байгуулсан.

ЗГХЭГ-аас 9 дүгээр сарын 5-ны өдрийн албан бичгээр захирамж хүргүүлэх тухай албан бичгийг Сангийн яаманд ирүүлсэн байгаа. Энэ хүрээнд Ерөнхий сайдын захирамжаар баталсан ажлын хэсэгт мэргэжлийн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий дэд ажлын хэсгийг Сангийн сайдын 2025 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 169 дүгээр тушаалаар байгуулсан бөгөөд дэд ажлын хэсэгт Монгол Улсын Шадар сайдын ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эдийн засгийн хөгжлийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, ХЗДХЯ, Монголбанк, ГЕГ, Татварын Ерөнхий газар, Эрдэнэс Монгол Оюу Толгойн ТУЗ-ийн гишүүд болон Эрдэнэс Оюу Толгой компаниудын төлөөллүүдийг хамруулж холбогдох судалгаа шаардлагатай ажлуудыг авч хэрэгжүүлж байна. Дэд ажлын хэсгийн хурлыг 2025 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсан бөгөөд хурлаар бид бүхэн ажлын хэсгийн баримтлах удирдамж, дэд ажлын хэсгийн зүгээс хийгдэх ажлын төлөвлөгөөг тус тус боловсруулж ажиллаад байна.

Дэд ажлын хэсгийн зүгээс 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 120 дугаар Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 2 сарын 11-ний өдрийн А29 дүгээр тушаалаар байгуулсан дэд ажлын хэсгээс хийгдсэн судалгаа, санал, дүгнэлтийг суурь болгон бид бүхэн холбогдох ажлын төлөвлөгөө болон судалгаагаа гүйцэтгэхээр ажиллаж байна.

Ажлын хэсгээс баримтлах удирдамж болон санал, дүгнэлтийг 3 дугаар улиралдаа багтаан Засгийн газрын хуралдаанаар танилцуулах бөгөөд Засгийн газрын хуралдаанаас гарсан холбогдох шийдвэр, санал дүгнэлтийг бид бүхэн ингээд дараа дараагийн Хянан хянан шалгах түр хорооны хурлууд дээр танилцуулаад явахаар ингээд төлөвлөөд ажиллаж байна аа. Мөн одоо бол Сангийн яамны зүгээс Хянан шалгах түр хорооноос албан шугамаар шаардсан холбогдох нотлох баримт, мэдээллүүдийг Хянан шалгах түр хороонд тухай бүр хүргүүлж Хянан шалгах түр хороон энэ үйл ажиллагааг дэмжин ажиллаж байгаа гэдгээ хэлмээр байна аа. Баярлалаа.

О.Батнайрамдал: Танилцуулга болчихсон уу? Ерөнхий сайдын захирамжаар бол ажлын хэсэг 8 сарын 19-нд сарын өмнө байгуулагдсан байгаа. Сангийн сайдаар ахлуулсан Оюу Толгой төслийн санхүүжилтийн хүүгийн зохистой байдлыг хянан авч үзэх, өөрчлөх асуудлаар хөрөнгө оруулагч талтай энэ хэлэлцээ хийж, санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах юм байна шүү дээ тэ?

Тэгэхээр та нар хэлэлцээр хийх ажлын хэсэг гэж ойлголоо тийм үү? Хэлэлцээр хийж Засгийн газрын хуралд танилцуулна. Тэгээд дэд ажлын хэсэг байгуулагдаад өчигдөр хуралдсан юм байна тиймээ. Өчигдөр тэгэхээр ямар ч байсан гэхдээ тэгвэл өчигдөр анхны хурлаа л хийсэн юм байна шүү дээ?

Гишүүд ингээд л болчхож байх шиг байна. Тэгээд гишүүд танилцуулгатай холбоотой асуулт асуух нэрээ өгцгөөе. Зулпхар гишүүнээр тасалъя. Зулпхар гишүүний микрофон.

С.Зулпхар: Баярлалаа мэдээлэл сонслоо.

Би нэг зүйлийг зүгээр тодруулах гээд байгаа нь энэ бас нэг ажлын хэсэг байж байгаа. 2024 оны 10 сарын 30-ны өдрийн Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хүрээнд байгуулагдсан ажлын хэсгүүд байгаа л даа. Тэгэхээр танай ажлын хэсэг энэ ажлын хэсгүүдтэй яаж уялдаж ажиллахаар байгаа юм бол? Тэрийг та бүхэн мэдэж байгаа юу гэдэг нэг ийм асуулт байна.

Хоёр дахь зүйл. Энэ нөгөө санхүүжилтийн зохистой байдалд дүн шинжилгээ хийх гэчихсэн байгаа. Санхүүжилтийн зохистой байдал бол алдагдчихсан байна гэдгийг бараг бид урьдчилаад дүн шинжилгээ хийгээд дүгнэлтээ гаргаад жишээ нь энд хэлэлцээд л явж байгаа л даа. Тэрний дагуу бүгдээрээ л ярьж байх шиг байна.

Тэгэхээр энэ дотор нэг ноцтой юм байгаа шүү дээ. Одоо энэ хүүгийн зээлийн хүүг яаралтай бид энийг хэлэлцээр хийж тогтоохгүй бол болохгүй гээд. Тэгэхээр танай ажлын хэсгийн анхны хуралдаан өчигдөр, уржигдар болсон юм байна. Тэрүүгээр та хэд энийгээ ярьсан уу? Энийг ер нь яая гэж та бүхэн хоорондоо ярилцаж тэгээд ямаршуу байдлын энэ асуудалд хугацааг нь дуусахаас өмнө шийдэлд хүрэх, эс үгүй бол нөгөө ажлын хэсэгтэйгээ уялдаж ажиллахаар шийдсэн бэ гэж байгаа юм. Эс үгүй бол хохирсон бэ? 98 хоног л үлдчихсэн гэдэг өнөөдөр надад тийм ойлголт байна.

Дээр Батнайрамдал гишүүн манай Түр хороон дарга хэлэхдээ бол 115 хоног л үлдлээ л гээд л тэгж байсан л даа. Тэр нь өдөр өдрөөр тоолохоор зэрэг удахгүй ингээд л энэ дуусчихвал тэгээд л Монголын тал ямар ч ажиллаагүй, санаачилга гаргаагүй, өөрсдөө ажиллаагүй юм чинь бид энэ яагаа ч үгүй гэдэг байдал дээр нөгөө тал чинь сууна шүү дээ. Нөгөө тал тийм л юм хүлээгээд сууж л байгаа байлгүй дээ. Энгийн логигоор аваад үзвэл. Тэгэхээр та бүхэн я ямаршуу байдлаар яг саяын 2 асуудал дээр ажиллахаар бэлтгэл хангаж байна вэ гэсэн ийм асуулт байна.

О.Батнайрамдал: Тодорхой асуулт асуулаа. Хэн хариулах вэ? 3 номерын микрофон. Амарбаясгалан дарга.

Б.Амарбаясгалан: Зулпхар гишүүний асуултад хариулъя аа.

Энэ өмнөх ажлын хэсгүүдээс гарсан холбогдох судалгаа болон ажлын тайлангуудыг бид бүхэн энэ дэд ажлын хэсгийнхээ хүрээнд энэ хурлаар болон албан шугамаар авч нийлүүлж байгаа. Энэ дээрээ бид бүхэн одоо энэ дэд ажлын хэсгийн удирдамжаар удирдамж гэж гарсан байгаа. Энэхүү удирдамжид туссан ажлууд нь яг бид нарын зүгээс тавих энэ аргумент дээр гаргаж ирэх энэ судалгаануудыг хийх ажлууд орсон байгаа гэж хэлмээр байна аа.

О.Батнайрамдал: Зулпхар гишүүн нэмэлт тодруулга.

С.Зулпхар: Яах вэ мэдээж хэрэг би тодруулах биш ер нь үг хэлье л гэж бодож байна л даа. Энд сууж байгаа бид бүгдээрээ л 1 дүгээрт Монгол төрийн ажлыг хийж

байгаа төрийн албан хаагч нар. Төрийн өмчит үйлдвэрийн газрын эрх бүхий удирдлагууд, цаашлаад жишээ нь төрийн өмчийн оролцоотой томоохон төслийн ТУЗҮ-ийн гишүүд сууж байна л даа. Тэгэхээр бидний хувьд бол Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2-ыг биелүүлэх ийм л зорилтыг хангахын тулд тал талаасаа үүрэг хүлээж байгаа гэсэн үг юм. Энийг та бүхэн надаас илүү сайн мэдэж байгаа байх гэж бодож байна. Уул уурхайн чиглэлээр мэргэшсэн улсууд учраас тэгэхээр энэ жишээ нь Оюу Толгой төсөл бол өөрөө бидний ойлгосноор бол Монголын жишээ нь Засгийн газрын оролцоотой Монголын төрийн нийтийн өмчийн оролцоотой ийм төсөл шүү дээ.

Тэгэхээр энэний цаана бол 3.5 сая Монголчуудын өөрсдийнх нь эндээс хүртэх ёстой үр өгөөж байж байгаа гэсэн үг. Тэгэхээр энийг бид хамтдаа ярьж байж энэ чинь бидний хамтын өмч, хамтын өмчөөс жишээ нь хамтдаа үр өгөөжөө хүртэхэд чиглэсэн ийм үйл ажиллагаа шүү гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Энийг бол эрхээ биш мэдэж байгаа гэдэгт эргэлзэхгүй байна. Гэтэл одоо нөгөө энэ хэлэлцээртэй холбоотой эхний ээлжид шийдэх ёстой зүйл бол их олон зүйл байгаа боловч эхнийх нь шүү дээ. Эхнийх нь бол саяын зээлийн хүүгийн асуудлыг яаралтай бид ярихгүй бол манай талын хүртэх үр өгөөж улам жишээ нь хойшлох эс үгүй л бол их тийм буурах ийм нөхцөл байдал байгаа юм. Бараг үр өгөөжгүй ч болохоор юм уу бүү мэд. Ямар нэгэн үр өгөөж байна л даа. Гэхдээ энэ бол хангалттай ерөөсөө биш. Энэ дээр ингээд эхлээд ажлын хэсэг байгуулчихсан. Одоо бол яаралтай шуурхай та бүхэн дээр шинээр ажлын хэсэг байгуулсан юм байна.

Та бүхэн энэ дээр их тийм ажил хэрэгч шуурхай ажиллаад өгөөч гэж байгаа юм. Энэ ерөөсөө бид нар хойшлуулж болохгүй, цааргалаад сууж болохгүй, эс үгүй бол ямар нэгэн юмтай танилцаад сууж болохгүй ийм хугацаа шүү дээ. Тэр битгий хэл ер нь шаардлагатай бол та бүхэн шиг ийм сүрхий экспертүүд 2 хоног суугаад л энийг чинь уншаад ойлгочих юм байна лээ шүү дээ. Яг л тийм л юм байна лээ. Бид ямар нэгэн байдлаар энэ салбараар мэргэшээгүй ч гэсэн 3, 4 хоног бүх цаасуудыг нь аваад уншаад үндсэнд нь ойлголтоо аваад тэгээд цаашлаад та бүхнээс асуусаар байгаад нарийн ширийн юмыг нь бол мэдчихсэн яавал бид илүү үр өгөөжөө авах вэ гэдэг тал дээр бол өөрсдийнхөө дүгнэлтийг гаргачихсан байж байгаа юм. Энэ дээр та бүхэн яаралтай жишээ нь төрийн албан хаагчдын хувьд эрх бүхий жишээ нь энэ төрийн байгууллагуудын оролцоо бүхий ажлын хэсгийн хувьд яаралтай энд ажиллаад өгөөч гэж байгаа юм. Ингэж байж бид нар үр дүнгээ үзнэ. Энэ бол 3.5 сая Монголчуудын энэ төсвөөс хүртэх үр өгөөжийн асуудал шүү.

Та бүхэн хариуцлагатай байж өгөөрэй гэж байгаа юм.

Баярлалаа.

О.Батнайрамдал: Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Бямбасүрэн гишүүнээр тасалъя. Болормаа гишүүний микрофон.

Э.Болормаа: Ингээд бүгдээрэнд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ хэлэлцээрийг хариуцаж байгаа сайд нар энд байх ёстой. Ийм чухал асуудал дээр ингээд дэд ажлын хэсгийн хүмүүсийг энд тавиад зовоогоод эд нар ажил хийхгүй байгаагаас болоод өнөөдөр ингээд Монгол Улсын эрх ашиг хөндөгдөөд байгаа юм шиг ийм нөхцөл байдал яваад байна л даа. Энэ уул уурхайн асуудал дээр аливаа нэг талд нэг юм ярихаар нэг попорч байна гэж нэг буруу ойлгоод байгаа юм. Энэ бүтэн жилжингээ л манай Батнайрамдал гишүүн энэ Онтрэ энэ хүүгийн асуудлыг

ярилаа. Попорч байгаа биш яг бодит Монгол Улсад ирэх өгөөжийг яаж нэмэгдүүлэх вэ? Монгол Улсын Үндсэн хуульд заасан 6.2 -оо буюу энэ өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдож байх гэдэг энийг яаж хэрэгжүүлэх вэ гэж байна. Энэ асуудал дээр хойрго хандаад нэг өдөр хойшлох тутам л бид нар нэг өдөрт зээлийн хүү 10 тэрбум төгрөг зарцуулж байна гэж байна шүү дээ.

Салбарын сайд нь тэнд очоод шинэ төсөл эхлүүлнэ, шинэ газрын ховор элементийн салбарт Монголд том тоглогч болно гээд ингээд мөрөөдлийн юм яриад байна л даа. Өмнөх ажлаа хиймээр байна. Өмнөх алдаануудаа засмаар байна. Иргэд бухимдаад байгааг чин сэтгэлээсээ ойлгохыг хүс. Юм болгоныг иргэдийгээ ингэж басамжилж бүдүүлэг харанхуй гэж ярьж болохгүй ээ. Яг энэ үр өгөөж нь ирэхгүй байгааг мэдээд байгаа учир иргэд эсэргүүцээд байгаа юм. Үнэхээр хариуцлагатай уул уурхай байгаад үнэхээр иргэдэд өгөөж нь ирдэг, байгаль орчны энэ тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй ингэвэл хэн ч энийг эсэргүүцээд явахгүй.

Монголчууд ухаантай энэ асуудлуудаа урагшил дуулаад л явна. Энэ өмнөх асуудлуудаа энэ олон лицензүүдээ аятайхан үр өгөөжтэй болгож чадахгүй болохоор ингэж байна шүү дээ. Өнөөдөр Улсын Их Хурлаар бид нар жишээлбэл Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авлаа. Ерөнхийлөгчийн Тамгын газраас өмнөх энэ 60 гаруй алтны лицензүүдийнхээ учрыг олохгүй байж байж юун тусгай хамгаалалттай газарт орж нэмж ухах вэ л гэж байгаа юм. Тэгэхээр энэ өмнөх өмнөх ажлуудаа хиймээр байна аа.

Түр хорооны дарга энэ сайд нарыг дууд. Улсын Их Хурлын гишүүд гэдэг чинь ард түмнийг төлөөлөөд энд сууж байна. Ард түмний санал бодлыг бид нар бодлогод тусгах гээд сууж байгаа болохоос биш энд попрох гээд, энд сайн муугаа хэлүүлэх гээд биш Монгол Улсын хөгжлийн ирээдүйн асуудал дээр цаг гаргаад сууж байхад яагаад энийг хийх ёстой хүмүүс нь өчигдөр дөнгөж анхны хурал нь болчихсон гадаад, дотоод хэсээд явж байдаг юм бэ? Би энийг ерөөсөө ойлгохгүй байна. Хүмүүс Монголын төсөл болгоныг дараагийн Оюу Толгой гэж яриад байх юм. Монголын ард түмний тал нь Оюу Толгой гэдгийг буруу гэж бодож байна. Магадгүй тал нь зөв гэж бодож байна. Дараагийн Оюу Толгой гэж яг юу яриад байгаа юм бэ гэдгийг хүмүүс асууж байна шүү дээ.

Тэгэхээр энэ урдах асуудлуудаа бүгдээрээ цэгцэлье. Өмнөхийг шүүх гэсэндээ биш, маш ажил хэрэгчээр энэ түр хороо ирээдүйг харсан бодитой 2 ажил хэрэгч саналуудыг хэлж байна. Засгийн газар энийг нэг ч өдөр алдахгүй ажиллах ёстой. Энэ сайд нар энэ ажлын хэсэгт байгаа бүх хүмүүсийг бусад асуудлаас нь бусад ажлуудаас нь чөлөөлөх ёстой. Энэ хүмүүсийн үндсэн ажил дээрээ энийг нэг хийх асуудал биш байхгүй юу. Өдөрт 10 тэрбум төгрөг зээлийн хүүд төлж байгаа энэ асуудал. Онтрэ бүлэг ордны энэ Оюу Толгой бүлэг ордны Онтрэ хэсгийн асуудал, энэ хүмүүсийн ажлын хэсгийн 1 дүгээр асуудал байх ёстой.

Тэгэхээр энэ дээр Түр хорооны дарга сайд нарыг дуудаж энэ Засгийн газар маш бодитой шийдэл хийх ёстой. Ер нь энэ асуудлыг нэг сайд биш бараг Ерөнхий сайд өөрөө ахлаад явж байх хэмжээний ч тийм чухал асуудал гэж хувьдаа харж байна.

О.Батнайрамдал: Сая Болормаа гишүүний хэлсэн яг үнэн шүү. Ач холбогдлоороо эрэмбэлэх юм бол Оюу Толгойн асуудал Монголын номер нэг асуудал байхгүй юу. Та нар Сангийн яамны залуучууд бүгдээрээ мэдэж байгаа.

Монгол Улсын нийт бүх гадаад өрийг аваад үзэх юм бол хэдэн хувь нь Оюу Толгой билээ. Мэдэж байгаа тиймээ 50-аас дээш хувь нь шүү дээ. 50-аас дээш хувь нь Оюу Толгой. Мөнгөн урсгалаар нь аваад үзсэн ч гэсэн хамгийн том төсөл. Сая Эрдэнэс Монгол ч гэсэн өөрсдөө хэллээ. Манай хамгийн том төсөл. Ач холбогдлоор нь авах юм бол Оюу Толгой гээд. Тэгэхээр энэ хамгийн ач холбогдолтой зүйлдээ Засгийн газар ч гэсэн төрийн өмчит Эрдэнэс Монгол ч гэсэн ач холбогдлынхоо эрэмбэ дээрээ 1 дүгээрт тавиач ээ. Энийг чинь ард түмэн хараад байна. 3.5 сая иргэн ямар шийдэл гаргаж ирэх нь вэ гэж бид нараас бүгдэнгээс нь нэхээд байна шүү дээ. Засгийн газартаа парламентдаа.

Тийм болохоор энэ дараа дараагийн хурал дээр бол хариуцсан сайд нар заавал ирэх ёстой. Бид нарт зориулж биш үү? Монгол Улсын 3.5 сая иргэндээ зориулж энэ хуралд өөрсдөө ирж тайлбараа тавиад өөрсдөө ирж хэлэлцээрийнхээ үр дүнгээ хамтдаа ярилцах ёстой шүү. Тэгээд яах вэ Сангийн яам бол бид нарт мэдээллээ нотлох баримтын хүрээнд бүх мэдээллээ гаргаж өгч байгаа. Гэхдээ хар даа сая бид нар Эрдэнэс Монгол тайлангаа тавиад явлаа. Юу ч хийгдээгүй юм байна. Тэгэхээр та нар юу ч хийгдээгүй юман дээр л орж байна. Эрдэнэс Монгол шиг байж болохгүй шүү. Материалыг нь татаж аваад богинохон хугацаанд бүгдээрээ ажиллахгүй бол бид нарт Зулпхар гуай гишүүн хэлсэн. 98 хоног л үлдсэн байна. Сангийн яамны залуучуудын чадавхад итгэж байна. Та нар чадна. Бид нар ард нь гарч чадна. Монгол Улсын талд байгаа Монгол Улсын эрхийг төлөөлж байгаа Улсын Их Хурал, Засгийн газар бид нар хамтраад хэлэлцээрт ороод эцэслэж чадна аа.

Хамгийн гол нь бид нар үр дүн гаргахын төлөө хамтдаа л энэ дээр зорих ёстой. Тэгэхээр дөнгөж өчигдөр дэд ажлын хэсэг байгуулагдсан байна. Бүх материалаа татаж аваарай. Яаралтай энэ дээр цаг хугацаа алдалгүй болж өгвөл Болормаа гишүүний хэлсэн шиг бусад ажлаасаа чөлөөлөгдөж байгаад энэ дээр хамгийн чухал 1 дүгээрт тавьж байгаад ажиллах ёстой шүү. Та нарын үр дүнг зөвхөн Хянан шалгах түр хороо биш 3.5 сая иргэн харж байгаа шүү. Тэгээд дараагийн удаа, дараагийн 3 дахь өдөрт яг энэ дэд ажлын хэсгийн хүрээнд юу хийгдсэн, тэгээд нэг чухал зүйл байна.

Ерөнхий сайдын захирамжийг би харж байна л даа 67 дугаар захирамж. Хөрөнгө оруулагч талдаа хэлэлцээр хийх ахлагч нь бол Сангийн сайд гэж ойлголоо шүү. Хөрөнгө оруулагч талдаа хэлэлцээр хийх ахлагч Сангийн сайд. Тэгэхээр одоо Жавхлан сайд хэлэлцээрт зээлийн хүүг ахалж орно гэж Ерөнхий сайдын захирамжаас бид нар ойлголоо. Тэгээд та нарт амжилт хүсье. Тэгээд Сангийн яамны залуучууд мундаг. Тэгэхээр та нар тэр мундгаа бусад зүйлээс гадна энэ Оюу Толгой дээр гаргаж ард түмэндээ нэг бэлэг бариасай л гэж чин сэтгэлээсээ бид бүхэн хүсэж байгаа юм.

Тэгээд дараагийн 3 дахид Хянан шалгах түр хорооны хурал дээр та бүхний тэгэхээр бүрэлдэхүүн юу байх юм, хэлэлцээрт яаж орох тактик байгаа юм? Ямар үр дүн гаргах юм? Ямар судалгаа шинжилгээ байгаа юм тэрийгээ хамтдаа Сангийн сайдтай хамтдаа бүгдээрээ танилцъя гэж бодож байна. Бямбасүрэн гишүүн үг хэлнэ.

Ш.Бямбасүрэн: Баярлалаа. Энэ өнөөдөр энд танхимд байгаа хүмүүстээ энэ өдрийн мэнд хүргэе. Энэ ОТ-г Хянан шалгах түр хороо байгуулагдаад ер нь маш их мэдээлэл сонсож байгаа. Тэгээд их юм сонсох тусам ер нь энэ Монгол Улс Оюу Толгой төсөл дээр ялангуяа Рио Тинтог энэ групптэй энэ харилцах ингээд нэг

цонхны бодлого алдагдчихсан юм байна аа. Тэгээд бүүр сүүлдээ Их Хурлаар энэ гэрээ орсон. Засгийн газар яг ямар үүрэгтэй юм? ТУЗ-ийн гишүүд ер нь яг энэ дээр яг ямар оролцоотой байх юм? Эрдэнэс Монгол, Эрдэнэс Оюу Толгой гээд компаниуд бүүр яг ингээд чиг үүргийн хувьд яг юу нь тодорхойгүй ингээд явчихсан. Тэгээд эндээс бол манай Монголын ТӨК-удын завхралыг харж болж байна.

Өнгөрсөн хугацаанд хийсэн ажлуудыг нь харахаар ингээд үнэхээр гүйцэтгэл муутай. Тэгээд үүсгэн байгуулсан энэ олон ажлын хэсгүүд тэд нарын энэ уялдаа холбоо, ажлын хэсгээс гарсан ингээд үр дүнг нь харахаар яг ингээд ерөөсөө ингээд ийм ямар ч уялдаа холбоо байхгүй. Яг энэ өнгөрсөн олон жил энэ Рио Тинто ОТ-гоор Монголчууд ярьж байгаа. Бүгд мэддэг юм шиг хэрнээ бүүр үнэхээр эмх замбараагүй ийм ойлгомжгүй байгаа нөхцөл байдалтай танилцаж байгаа юм.

Тэгээд 2025 он бол үнэхээр чухал он гэдгийг манай энэ Хянан Шалгах түр хорооны гишүүд давтан давтан хэлж байгаа. Хугацаа бол үнэхээр богино байгаа. Тэгээд энэ Сангийн яамнаас байгуулсан энэ дэд ажлын хэсгийнхэн маань үр бүтээлтэй ажиллаарай.

Битгий ийм өмнөх ажлын хэсгүүд шиг одоо үр дүнгүй цаг нөхцөөсөн байдлаар хандаарай. Ер нь энэ бид нар энэ Оюу Толгойн өнгөрсөн хугацаан дээр ингээд болсон энэ олон эс үйлдлүүдээр бид нар хариуцлагын асуудлыг ер нь сөхөж гаргаж тавих ёстой юм байна аа. Яг энэ түр хороон дээрээс бол бид нар зөвхөн энэ хүүг бууруулах биш ер нь яагаад өнгөрсөн хугацаанд ингэж санаатай юм уу, санаандгүй юм уу ийм эс үйлдэхүйгээр ингэж олон юман дээр хандаж ирсэн юм. Тэгээд яг ингээд ингээд бөмбөг шиг ингээд нэг нэгрүүгээ пасслаад явчихсан. Тэгээд сүүлдээ ингээд ярьж байгаа юм нь болохоор ингээд бүр тэр бүр ингээд аргачлалын зөрүүтэй болохоор ийм байдаг гээд.

Ингээд Эрдэнэс Оюу Толгойнх нь нөхдүүд нь ийм арга ядсан юм яриад байгаа юм. Үгүй энэ чинь 2 талаасаа суугаад л тохиролцоод л аргачлалаа энэ дээрээ тогтёо гээд л тогтчих л асуудал шүү дээ. Ерөөсөө 2 тал ширээний ард суугаад тэгээд өнөөдөр яг хэн нь тэгж суух нь тодорхойгүй. Засгийн газраас нь юм уу, Хэрэг эрхлэх газраас нь юм уу, энэ Эрдэнэс Монгол нь уу, Оюу Толгой нь юм уу. Хэн нь суух нь ийм тодорхойгүй. Ингээд яваад ирчихсэн байгаа өнгөрсөн хугацаанд. Тэгэхээр Оюу Толгойн асуудлыг бид нар нэгэнт энэ Хянан шалгах түр хороо байгуулагдсаныг маш нухацтай харж үзээд өнгөрсөн хугацаанд яг хаана ямар алдаа дутагдал гарч байсан гэдгийг бид нар маш нухацтай ярих ёстой. Энэ нь бол хэн нэгнийг одоо буруутгах, шийдэх гэхээсээ илүү цааш цаашдаа бид нар ийм алдаа дутагдлыг гаргаж болохгүй гэдэг үүднээс яг энийг бол зайлшгүй хийх шаардлагатай юм байна.

Тэгээд Хянан шалгах түр хороон дээр нэг гишүүний зүгээс зүгээр л ажлын хэсэгтээ хурдан шуурхай ажиллаад бид нарт одоо үнэн зөв мэдээллийг яаралтай өгөөч үр дүнтэй ажиллаасай гэж та бүхнээсээ чин сэтгэлээсээ хүсэж байна.

Тэгэхгүй бол өнөөдөр бид нар ингээд л тал талаас мэдээлэл сонсоод л байна. Тэгэхдээ үнэхээр явц муутай байна. Бүр манай Батнайрамдал гишүүн хэлж байна шүү дээ. Бүүр 2018 оны ажлын хэсгийн дүгнэлтийг битгий яриад байгаач гэж. Үнэхээр энэ Их Хурлын энэ ордонд энэ индэр дээрээс ийм үгийг хэлнэ гэдэг бол үнэхээр Монголын төр ямар арчаагаа алдчихсан замбараагүйгээ л ер нь л харуулж байгаа юм. Ер нь бол тэгэхээр бид нар хариуцлагын асуудлыг заавал ярих ёстой. Тэгээд үнэхээр муу ажиллах юм бол бид нар энд орж ажилласан бүх хүмүүс дээр ер

нь хариуцлагын асуудал яригдана шүү. Дараа нь бол бид нар дээр нуруун дээр энэ асуудал унана шүү гэдгийг бодож санаж хариуцлагатай ажиллаарай гэж та бүхнээсээ хүсье. Баярлалаа.

О.Батнайрамдал: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлж дууслаа. Баярлалаа. Ажлын хэсэгт баярлалаа.

14.08 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны дол 73 дугаар захирамжаар байгуулагдсан стратегийн ач холбогдол бүхий Оюу Толгой бүлэг ордын талбайн хил зааг дотор ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг Онтрэ компанийн хувьцааны төрийн эзэмших хувь хэмжээг Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох талаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, холбогдох асуудлыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам танилцуулна.

Танилцуулгатай холбогдон хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя.

Өнөөдөр Дамдинням сайд ирж амжаагүй байгаа. Засгийн газрын хурал явж байгаа гэж ойлгосон.

Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны уул уурхайн бодлогын газрын дарга, Хулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга, Зууннаст АМГТГ-ын хайгуул ашиглалтын газрын уул уурхайн хэлтсийн дарга, Цэгц АМГТГ-ын уул уурхайн хэлтсийн судалгаа мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны газрын дарга мэргэжилтнүүд ирсэн байна. Зууннаст дарга хаачсан ирж байгаа юу? Зууннаст даргыг дуудъя.

Танилцуулга хийх ажлын хэсгийн микрофоныг өгье. Танилцуулга хэн хийх үү? 4 номерын микрофон Намчинсүрэн дарга. Бид нарт одоо 25 минут үлдсэн байгаа. Тэгэхээр танилцуулгаа маш богинохон яг түүхэн замнал биш яг ямар ажил хийгдэж байгаа юм. Үр дүн юу байгаа юм. Ямар хэлэлцээрээр явж байгаа юм. Яг тэрийгээ маш товч тодорхой яриарай. Намчинсүрэн дарга.

Г.Намчинсүрэн: УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан Хянан шалгах түр хорооны дарга болон гишүүдэд өдрийн мэнд хүргэе.

Ер нь Монгол улсын Ерөнхий сайдын захирамжаар бол 4 жлын хэсэг гарсан байгаа. Хянан шалгах түр хорооны даргын хэлсний дагуу үндсэндээ бол гол гол мэдээллүүдээ өгөөд явчихъя гэж бодож байна. Ер нь бол бүлэг ордын геологийн нөөцийн бол хүдрийн нөөцийн 32 хувийг бол Онтрэгийн тусгай зөвшөөрөл ер нь талбай дахь нөөц бол хамаардаг. Тухайлах юм бол Онтрэгийн талбай дээр байгаа хүдрийн нөөц нь нийт бол 2 орчим тэрбум хүдрийн нөөцтэй. Үүнийг нь бол металлаар нь салган авч үзвэл зэсийн 24 хувь буюу 10.3 сая тонн зэсийн нөөцтэй.

Алтны 759 тонн буюу нийт нөөцийн нэг 41 хувийг бол бүрдүүлж байгаа. Мөнгөний бол 3400 тонн буюу 28 хувийг нь бол бүрдүүлж байгаа. Молибдены бол нийт 94 хувь буюу 190 мянган тонн хүдрийн нөөцийг бол Онтрэ ХХК-ийн тусгай зөвшөөрлүүд дээр бүртгэгдсэн байдаг аа. Энэ хувь эзэмшигчийн бүтцийн талаар бол ярих нь зүйтэй байх. Монгол Улсын Засгийн Туркойз Хиллстэй хамтраад бол энэ Оюу Толгой төслийг бол хамтран хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж хэрэгжүүлж байгаа. Үүн дээр бол Монгол Улсын Засгийн газрын 34 хувь Туркойз Хиллс нь 66 хувь Туркойз Хиллс нь өөрөө Рио Тинто 100 хувь Рио Тинтогийн 100 хувь охин компани. Тэгэхээр энэ дээрээс бол ахиад Рио Тинто нь Туркойз Хиллс болон Рио Тинтогоороо өөрөө дамжаад энэ Антрэ компанийн толгой компани болох Онтрэ Ресурс компани бол 16.5 хувийг эзэмшиж байгаа. Энэ Антрэ болон Оюу Толгойн хооронд бол арбитрын маргаан үүссэн байдаг. 2024 оны 12 сарын 19-ний өдөр бол арбитрын шийдвэр гарсан. Энэ дээр бол Антрэ ресурсийн 2004 оны хамтран ажиллах гэрээг бол баталгаажуулах шийдвэр гаргасан. Мөн тусгай зөвшөөрлүүдийг шилжүүлэх асуудал бол арбитрын маргаан дээр бол шийдвэр нь гарсан байдаг аа.

Тэгэхдээ тусгай зөвшөөрөл шилжүүлэх асуудлыг бол тухайн улсын хууль тогтоомжийн дагуу гэдэг бол ойлголт байгаа гэж байгаа. Тэгэхээр бол одоо тусгай зөвшөөрөл шилжүүлэх процесс бол Татварын ерөнхий газар дээр байгаа. Энэ дээр бол нөгөө Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрөл шилжсэн тохиолдолд 10 хувийн татварыг ноогдуулах зохицуулалттай. Хөрөнгө оруулалтын гэрээнд ер нь Антрэгийн асуудлууд яаж туссан юм бэ гэдэг дээр тайлбар өгөх ёстой болох байх. Тэгэхээр Антрэгийн Антрэ ХХК-ийн толгой компанийн Онтрэ Гоулд компани нь 2008-аас 9 онд Оюу Толгойн хэлэлцээрийн талд байгаагүй. Түүнд оролцоогүй, түүнтэй холбоотой хэлцэл хийгдээгүй гэж бол үзэж байгаа. Антра ХХК-ийн Онтрэ Гоулд компани нь хөрөнгө оруулалтын бол өөрөөр хэлбэл ОТ-той байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээний бол тал биш гэж бол үзэж байгаа.

Дараагийнх нь бол энэ тусгай зөвшөөрлийн талбайнууд нь энэ талбай дээр энэ хөрөнгө оруулалтын гэрээнд бол хамаарах нөхцөл байхгүй гэж бол үзэж байгаа. Тухайлах юм бол хөрөнгө оруулалтын гэрээний 16.11, 16.25-ын дагуу хөрөнгө оруулалтын гэрээний үйлчлэх хүрээнд 6708, 6709 болон 6710 тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүд, түүний эдэлбэр газар хамаарахаар тусгагдсан байдаг. Антрэ компанийн эзэмшиж буй ашигт малтмалын 2 тусгай зөвшөөрлүүд нь хөрөнгө оруулалтын үйлчлэлд бол хамаарахгүй байдалтай байгаа. Үүнтэй холбоотой бас нэмээд мэдээлэл өгье.

Оюу Толгойн бол ТЭЗҮ бол Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаман дээр бол ирсэн байдаг. 2023 онд ирээд ТЭЗҮ дээр нь бол холбогдох шинжээчдийн баг бол ажиллаад дүгнэлтээ гаргаад 2024 оны 8 сард Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар орсон. Мэр ТЭЗҮ дээр бол Антрэ компанийн эзэмшиж байгаа 2 тусгай зөвшөөрөл бол хойд олборлолтод өртөхөөр байгаа талбай дээрээсээ одоогийн хөрөнгө оруулалтын гэрээнд заасан тогтворжуулалтыг эдлэхээр бол орж ирсэн байдаг.

Тэгэхээр бид нар бол Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл дээр бол энэ асуудлуудыг хэлэлцээд 13 асуудлаар бол албан даалгавар өгөөд ТЭЗҮ-ийг буцаасан байдаг аа. Ер нь энэ компанийн эзэмшиж байгаа лицензүүд нь хөрөнгө оруулалтын үйлчлэлд ер нь хамруулах нөхцөл байгаа юм уу гэвэл нөгөө хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдсан 15.5-д заасны дагуу Засгийн газарт хүсэлтээ

бичгээр хүргүүлээд харилцан тохиролцож шийдвэрийг гаргуулах бол шаардлагатай гэж бол үздэг ээ.

Энэ бид нарын зүгээр энэ дээр асуудал дээр юу байгаа вэ гэхээр тусгай зөвшөөрөл шилжээд яваад зүгээр нэг болгоомжлол байгаа нь тусгай зөвшөөрөл шилжээд Оюу Толгой руу шилжчихвэл яг энэ 15.5-д заасан нөхцөл бүрдчих эрсдэл байна гэж хараад байгаа юм. Тэгэхдээ Татварын ерөнхий газар дээр бол татварын 10 хувь ноогдуулалтын бол асуудлуудыг хөндөөд явж байгаа. Ер нь цаашид хийгдэх ёстой ажлууд гэвэл мэдээж Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2-т заасны дагуу байгалийн баялаг, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа түүний үр өгөөжийг дийлэнх нь ард түмэнд ноогдож байх зарчмыг хангуулах шаардлага бий. Монгол Улсын Үндсэн хуулийг дагаж гарсан 2020 оны 2 дугаар тогтоолоор өгөөж гэдэг ойлголтод татвар ноогдол ашиг гээд бол тусгачихсан байдаг. Өөрөөр хэлбэл сая Эрдэнэс Оюу Толгойнхон маань ч ярьж байх шиг байна. Эрдэнэс Монголынхон маань ч ярьж байх шиг байна. Өөрөөр хэлбэл энэ хөрөнгө оруулалтын гэрээ, Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд тэр өгөөж гэдэг ойлголттой бол харилцан тохиролцоогүй байдаг талууд үүнээс улбаатай бол дараа дараагийн маргаанууд үүсээд яваад байдаг.

Мөн Үндэсний баялгийн сангийн тухай хууль болон Ашигт малтмалын хуульд заасны дагуу.

О.Батнайрамдал: Намчинсүрэн дарга аа цаг байгаа байгаа. Та авч хэрэгжүүлсэн одоог хүртэл хийсэн арга хэмжээгээ ярьчих. Ерөнхий мэдээллийг бид нар хангалттай авсан. Мэдэж байгаа. Тэрэн дээр цаг үрэх хэрэггүй. Яг ямар захирамж гараад ямар ажлын хэсэг гараад хэн хариуцаад одоог хүртэл яг юу хийсэн бэ? Юу хийхээр төлөвлөж байгаа юм. Монгол Улсын Ерөнхий сайдын бол 4 захирамж гарсан. 2025 оны 7-оос. 67, 68, 73, 74 Онтрэтэй бол хэлцэл хийх бол төрийн эзэмшлийн хувь тогтоох хэлцэл хийх бол ажлын хэсэг нь өөрөө энэ захирамжид, 68 дугаар захирамжид байгаа.

67 дугаар захирамжаар бол сая Сангийн яамныхан маань танилцуулаад гарлаа. Өөрөөр хэлбэл нөгөө зээлийн хүүг бууруулах асуудал дээр Сангийн сайд ахалж байгаа. 68 дээр нь бол Улсын Их Хурлын 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг бол Дамдинням сайд ахалж байгаа. 74 дээр нь бол Арбитрын асуудал явж байгаа. Ер нь эцэст нь дүгнээд хэлэх юм бол энэ Засгийн газар дээр бол энэ 4 ажлыг нягт уялдаатай, хооронд нь харилцаатай авч яваад түргэн шуурхай асуудлуудаа шийдвэрлээд явна гэсэн бол зорилтыг тавьж байгаа. Ер нь энэ ажлууд дээр ингээд төрийн яамдуудын зүгээс ингээд харах юм бол ихэвчлэн бусад ажлын хэсгүүд дээрээ дэд ажлын хэсэг гараад ажиллахаар ер нь бол гишүүд нь давхцалтай тийм байдалтай байдаг.

Тэгээд сая бол бид нар 103-ынхаа асуудлаар бол сүүлд 2 өдөр дэд ажлын хэсгээ байгуулаад хуралдуулсан бол Антрэг араас нь түлхээд явна. Нөгөө талд нь арбитрын маргаан бол яаж шийдвэрлэгдэх вэ гэдгийг харах байдалтай байна аа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

О.Батнайрамдал: Нэмээд хэлчихье. Ер нь энэ төрийн эзэмшлийн хувь тогтоох асуудал яаж бий болсон юм бэ гэж үзэх юм бол ер нь стратегийн ордын хил хязгаарыг бол Засгийн газар батлахаар хуульчлаад өгчихсөн. Энэ хүрээндээ бол

Засгийн газраас 2025 оны 4 дүгээр сард Оюу Толгойн ордын хил заагийг бол тогтоож өгсөн байдаг. Энэ хил заагт бол Антрэгийн 2 тусгай зөвшөөрлийн талбай хамрагдсан. Үүнтэй холбогдуулаад бол бид нарын зүгээс бол энэ компанитай төрийн эзэмшлийн хувийг бол тохиролцох нөхцөл бүрдсэн гэж үзэж байгаа. Баярлалаа.

О.Батнайрамдал: Презентац танилцуулга дахиад л яг юу хийсэн бэ гээд байгаа шүү дээ. Хийсэн юм байна уу? Ажлын хэсэг гарснаас хойш. Цаашдын төлөвлөгөө авч хэрэгжүүлэх гэж байгаа арга хэмжээ юу вэ? Ямар ч байсан унтраах хөрөнгө оруулалтын гэрээнд хамаарахгүй гээд л тийм хамаарахгүй гэсэн дүгнэлт л хэллээ. Тэгвэл та Ерөнхий сайдын захирамж гарчихсан байна шүү дээ. 73 дугаар захирамж 8 сарын 22-нд гарсан байна. Тэгэхээр та нар сарын хугацаанд яг юу хийсэн бэ? Юм хийж байна уу үгүй юу? Ажлын хэсэг хуралдсан уу? 103 дугаар Захирамж Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах бүр энэ гэхдээ бид нарын хүрээ хязгаар биш шүү. Гэхдээ аминд тулчихсан байгаа зүйл чинь Онтрэ шүү дээ, зээлийн хүү.

Тэгэхээр та сая 103-ынхаа хэрэгжилтийнхээ дараа нэг Онтрэг авч үзнэ гээд хэлчхэв үү? Тийм юм байхгүй шүү. Онтрэгийнхаа асуудлыг эхлээд шийднэ шүү дээ. Ер нь гишүүдээ бүгдээрээ нэг Улсын Их Хурлын чиглэл гарсан хүмүүс л юм байна. Шаардлагатай бол Улсын Их Хурлын чиглэл өгч болно оо. Дараагийн 7 хоногт нэгдсэн хуралдаанаар оруулах хэрэгтэй юм байна. Бид нар Хянан шалгах хорооноос гишүүдээс санаачлаад хуралдаанаар оруулах бүрэн эрх байгаа. Бүрэн эрхээр нэгдсэн хуралдаанд дараагийн 7 хоногт оруулах ёстой юм байна. Тэгье.

Тэгэхээр нэг иймэрхүү л чиг харагдаж байна даа тэгээд. Танилцуулгатай холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье.

Асуулт асууж, үг хэлэх зэрэг явчихъя. Болормаа гишүүнээр тасалъя. Пүрэвдаваа гишүүний микрофоныг өгье.

Д.Пүрэвдаваа: Уул уурхайн яам тийм ээ. Би нэг ийм нөгөө Оюу Толгой чинь Онтрэгийнхээ талбай руу орчихсон гэж ойлгож байгаа. Яг тэр орох процесс дээр яам ямар хяналт тавьсан юм. Тэгээд бид нар чинь бол Арбитрын шийдвэр гарсны дараа л ингээд л Их Хурлын түвшинд мэдээлэл аваад үйл ажиллагаа явж байна шүү дээ. Тэгээд процессын хувьд Монгол Улсын баялгийг тийм Оюу Толгой компани өөр гэрээтэй Онтрэ компани өөр талбай байгаад байдаг. Өөр хуулиар зохицуулагддаг, өөр журмаар зохицуулагддаг. Яам тэгэхэд хаана байсан юм бэ? Хяналт шалгалт хийдэг өдөр тутам л процесс нь байх ёстой шүү дээ Оюу Толгойн үйл ажиллагаа гаднын хөрөнгө оруулалттай компаниуд дээр хяналт тавих үйл ажиллагаа нь бол мэргэжлийн байгууллагуудад байх ёстой.

Тэр үед та бүхний тэмдэглэл алдаа хаана гарав, хэзээнээс гарав? Тэгээд арбитрын шүүхээр тогтоогдоод маргаанууд нь эцэслэгдээд миний ойлгосноор Онтрэ тал нь арбитр дээрээ ерөнхийдөө яллаад тэгээд ингээд зөвшилцөлд хүрсэн юм байна гэж ойлгож байгаа. Энэ Оюу Толгой компани Онтрэ компани зөвшилцөхөд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж хэн оролцсон бэ? Ямар шийдвэр гарсан бэ? Тэгээд эдгээрээс тооцож үзээд бид хохирсон уу? Хохирсон бол ямар хэмжээгээр эсвэл боломжит боломжоо алдсан бол ямар хэмжээгээр. Тэгээд тодруулъя.

О.Батнайрамдал: Пүрэвдаваа гишүүн маш тодорхой асуулт асуулаа шүү. 4 номерын микрофон. Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя аа.

Г.Намчинсүрэн: Үндсэндээ бол Антрэд дээр бол талбай руу бол зөвхөн нэвтрэлт бол орсон байгаа. Өөрөөр хэлбэл хүдрийн олборлолт явагдаагүй гэж шууд хэлж болно. Үндсэндээ 2024 онд бол 284.2 эквивалент метр хөндлөн огтлолт малталт хийх байснаас бол 49.8-д нь бол хийсэн байдаг. 2025 онд бол 1600 эквивалент метр хөндлөн огтлолт хийхээс бол одоогоор бол энэ ажил бол хийгдээгүй байгаа. Төлөвлөсөн боловч хийгдээгүй байгаа. Одоо бол Оюу Толгой компаниас бол Антрэгийн талбай руу бол одоогоор бол үндсэндээ 49.8 эквивалент бол нэвтрэлтийн бол ажил хийгдсэн байгаа. Оюу Толгой компаниас бол техник эдийн засгийн уулын ажлын төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулаад нэвтрэлтийн чиглэлээ бол өөрчлөх хүсэлтийг бол манай яаманд ирүүлсэн байгаа болчихсон уу хариулт.

Пүрэвдаваа гишүүн тодруулъя.

Д.Пүрэвдаваа: Ингээд байна шүү дээ арбитр дээр Оюу Толгой Онтрэ 2 маргаад тэгээд нэг шийдвэр гарчихлаа. Тэрний дараа Улсын Их Хурал олж мэдлээ. Тэр процесс нь наана нь явагдсан байж таараа шүү дээ. Тэр маргаан болж байх процесс ялангуяа айлын тал руу нэвтэрсэн Онтрэ компанийн үйл ажиллагаа руу Оюу Толгой компанийн тодорхой хэмжээнд үйл ажиллагаа оролцсон байдал байна. Та сая олборлолт явуулаагүй ээ. Тэгэхдээ ямар нэгэн үйл ажиллагаа явсан байна шүү дээ. Тэгэхэд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж хэн байсан юм бэ? Ямар байгууллага хариуцдаг юм бэ? Хэзээ олж мэдсэн юм бэ? Асуугаад байна шүү дээ, Ойлгогдохгүй байна.

О.Батнайрамдал: 4 номерын микрофон. Гишүүн тодорхой асуулт асуугаад байна даа.

Г.Намчинсүрэн: Ер нь бол арбитрын маргааны асуудлыг бол ХЗДХЯ бол хариуцаад явдаг. Манай дээр бол уулын ажлын төлөвлөлтийн асуудлууд байдаг. 2024 онд л ер нь бол нэвтрэлт хийх төлөвлөлт орж ирсэн. Үүн дээр нь бол 284 түрүүний хэлдэг тоо. Бид нар манай дээр бол манай дээр нэвтэрсэн байгаа тоо нь бол 49.8 эквивалент метр куб малталт бол явсан. Төлөвлөгөө тайлантай холбоотой болон үндсэндээ сая төрийн эзэмшлийн хувь тогтоосонтой холбогдуулаад Оюу Толгой компаниас бол цаашид Антрэгийн талбай руу нэвтрэлт хийхгүй ээ. Төрийн эзэмшлийн хувиа тохиролцож байж энэ асуудлуудаа цааш нь авч явна гэдгээ бол илэрхийлээд манай яам руу бол төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулах бол хүсэлтийг ирүүлсэн байгаа.

О.Батнайрамдал: Пүрэвдаваа гишүүнд нэмэлт минут.

Д.Пүрэвдаваа: Ийм байна. Манай яам маань энэ салбарынхаа бодлогыг, хяналтыг, хуулийн хэрэгжилтийг хариуцаж байх ёстой байгууллага байхгүй юу даа. Ажиллагаа явуулж байгаа гүний уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа компанийн үйл ажиллагаан дээр танай салбар хяналт тавьж чадахгүй байна л гэдгийн л илэрхийлэл. Өнөөдөр та бүхэн харуулж байна шүү дээ. Ямар ч хариуцах эзэнгүй байна шүү дээ. Бид нар сар тутамдаа 7 хоног тутамдаа ч гэдэг юм уу ийм ийм протоколоор энэ чинь Засгийн газрын тогтоолтой санагдаж байна. Уулын ажлын төлөвлөгөө дээр ер нь явц дээр нь хяналт тавьдаг бүр Засгийн газрын тогтоол

журам байдаг санагдаж байна. Би Монгол Улсын маш олон уул уурхайг хянаж шалгаж тийм явж байсан тохиолдол байсан юм. Олон шийдвэрүүд.

О.Батнайрамдал: Пүрэвдаваа. Гишүүн нэмэлт минут.

Д.Пүрэвдаваа: Тэгээд өнөөдөр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа компани дээр хяналт тавих журам, шийдвэр бол хангалттай байгаа юм. Тэгээд тэрийгээ та нар яагаад биелүүлээгүй яг хэн хариуцаж байсан юм гэдэг асуудал ердөөсөө тодорхой хэлж чадахгүй байна гэдэг чинь танай л салбарын л одоо доголдол алдаа мадаг биз дээ. Хүн маргалдсаны дараа бид нар нээрээ энд ийм асуудал үүссэн байна гэдгийг олж мэднэ гэдэг чинь л өөрөө л бид нарын л алдаа байна гэсэн үг шүү дээ. Та нар төрөө төлөөлж чадахгүй байна шүү дээ. Хэлэх үг дууслаа. Баярлалаа.

О.Батнайрамдал: Онтрэгийн талбай Онтрэ гэдэг чинь шал ондоо компанийн эзэмшил дээр байгаа тийм үү? Оюу Толгой дээр байгаа лиценз биш тэр. Өөр компанийн эзэмшилд байгаа лиценз рүү малталт орж болдог юм уу, тэрэн дээр ямар нэгэн хяналт тавигдсан уу? Тэрэн дээр хэн нэгэн зөвшөөрөл өгсөн үү? Эсвэл зөвшөөрөлгүй тэр асуудал хийгдсэн үү гэж асуугаад байна шүү дээ.

Тэгэхээр энийгээ тодорхой болгох хэрэгтэй шүү. Наадхын чинь ард ноцтой асуудал яригдана гэсэн үг. Монгол Улсын хууль тогтоомж биелсэн үү, үгүй юу, хэрэгжсэн үү, үгүй юу. Хэрэгжсэнд хяналт тавигдсан уу үгүй юу гэдэг маш том асуудлууд Пүрэвдаваа гишүүн асуугаад байна шүү дээ. Тэгэхээр дараагийн хурал дээрээ та нар энэ бүхэн дээрээ ойлгомжтой тайлбартай ирнэ шүү.

Дараагийн 3 дахид бид нар 7 хоног болгон хуралдана. Үүнээс хойш. Зулпхар гишүүний микрофон.

С.Зулпхар: Ажлын хэсгийнхний өдрийн амгаланг айлтгая аа. Сая гишүүд ч гэсэн асуугаад байна. Улсын Их Хурал бол хууль тогтооно. Засгийн газар хуулийн хэрэгжилтийг хангана. Эргээд хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангуулсантай уялдуулаад Улсын Их Хурал өөрөө хяналт тавих ийм чиг үүрэгтэй ийм л тогтолцоо үйлчилж байгаа учраас бид өнөөдөр энд Түр хороо байгуулагдчихсан та бүхэнтэй уулзаад байж байгаа гэдгийг та бүхэн сайн мэдэж байгаа байх гэж бодож байна.

Би зүгээр энгийн логикоор л асуулт асууя. Бидэнд өгөгдсөн өнгөрсөн 2 жил 2 сарын хугацаан дахь авагдсан мэдээллээр бол Оюу Толгой бүлэг орд дээр 5 лиценз байна. Гурав нь бол өөрөө Оюу Толгой ХК дээр энэ лицензийнхээ дагуу одоо үйл ажиллагаа явуулж байна. Хоёр лиценз нь бол Онтрэ гэдэг компани дээр байгаа. Тэгэхээр энэ 2 хоёулаа тусдаа хуулийн этгээд байгаа. Хоёр тусдаа хуулийн этгээдэд бол тус тусад нь энэ лицензүүдийг зөвшөөрөл болгоод өгчихсөн юм гэдэг нэг ийм ойлголт байгаа юм, 1 дүгээрт.

Тэгээд энэтэй уялдуулаад манай орд угаасаа стратегийн ач холбогдол бүхий орд гэдгийг бид ингээд тогтоочихсон. Тийм бүлэг нь өөрөө тийм. Тэр битгий хэл жишээ нь та бүхний өгсөн мэдээлэл бидний мэдэж байгаа мэдээлэл бол энэ бүлэг ордын чинь зэсийнх нь нөөцийн 24 хувь нь буюу 10.3 сая нь Онтрэ дээр байж байгаа. 41 хувь нь бол алтных нь 41 хувь нь бол мөн Онтрэгийн лиценз бүхий талбай дээр байж байгаа, мөнгөнийх нь 28 хувь гэх мэтчилэн. Хүссэн ч хүсээгүй ч 2 лиценз байлаа ч гэсэн энэ бол стратегийн орд.

Тийм учраас нөгөө Үндсэн хуулийн 6.20. Тэрэнтэй уялдуулан ашигт малтмалын тухай хуульд оруулсан тэр заалтуудтай уялдсан байдлаар энийг ашиглахтай холбоотой зөвшөөрөл зохицуулалт энэ бүгд та бүхэн дээр байгаа юм байна л гэж ойлголоо. Миний үндсэн ойлголт.

Тэгэхээр саяын гишүүдийн асууж байгаа нэг зүйл байгаад байна шүү дээ. Энэ Оюу Толгой хэрвээ Онтрэгийн тэр нөөцийн талбай руу нэвтрэлт хийчихсэн юм бол энэний хяналтыг жишээ нь яаж тавих ёстой байсан юм. Ер нь тавьсан юм уу, тавиагүй юм уу гэдэг асуудал. Тэгээд хэрвээ тавиагүй бол энэ чинь хууль зөрчлөө гэсэн үг шүү дээ. Хууль зөрчсөн ойлгомжтой шүү дээ. Тэгэхээр энэнтэй холбоотой та бүхэн ямар нэгэн захиргааны процесс хийсэн үү? Онтрэ рүү бичиг явуулсан уу? Оюу Толгой ХХК руу бичиг явуулсан уу. Эд нар юу гэдэг хариу өгч байна гэдэг нэг ийм асуулт гарч ирээд байна. Энийг эхлээд хэдүүлээ хариултыг нь авчхаад тэгээд дараа нь мэдээжийн хэрэг та бүхэн ажлын хэсэг ажиллаад эхлэх байх. Бид бол харин ч харьцангуй тодорхой хугацаанд ажиллаад үр дүн гаргачихаар ийм хугацаа байгаа учраас энэ дээр бол хэлэлцээд явах боломжтой байх.

Би эхлээд асуултынхаа хариултыг авчихъя.

О.Батнайрамдал: Зулпхар гишүүний асуултад хариулах уу? 4 номерын микрофон.

Г.Намчинсүрэн: Зулпхар гишүүний асуултад хариулъя. 2024 онд бол нэвтрэлт явсан гээд би түрүүн хэлсэн. Үндсэндээ энэ бол тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бол өөрийнх нь бол төлөвлөгөө тайлан дээр бол тусаж явах ёстой. Тэр хүрээндээ 2024 онд бол Ашигт малтмал газрын тосны газарт Онтрэгээс өөрөө бол манай талбай дээр нэвтрэлт явсан гэдэг бол тайлангаа бол өгсөн байдаг аа.

О.Батнайрамдал: Зулпхар гишүүнд нэмэлт тодруулга.

С.Зулпхар: Би нарийн процессыг нь мэдэхгүй юм. Нэвтэрсний дараа тайлан өгсөн юм байна тийм ээ нэвтэрч явчихлаа гэж. Гэхдээ нэвтрэхийн тулд зөвшөөрөл авдаг уу? Одоо энэ яаж зохицуулагдсан байдаг юм. Тэгээд зүгээр нэвтэрчихлээ гээд ингээд нэг ийм тайлан өгчихөөр бүх зүйл ингээд шийдэгдэхээр тийм эрх зүйн орчинтой бид нар байгаа юм уу? Ямар байгаа юм бэ л гэж.

О.Батнайрамдал: 4 номерын микрофон тодорхой хариулъя.

Г.Намчинсүрэн: Оюу Толгой компани бол 2024 онд бол энэ Антрэгийн энэ талбайд бол нэвтрэх төлөвлөгөөгөө бол батлуулсан байдаг АМГТГ-аар. Энэ төлөвлөгөөг батлуулахдаа бол Антрэ нь бол өөрөө зөвшөөрсөн зөвшөөрлөө бол энэ төлөвлөгөөг батлуулахад өгсөн байдаг. Тэр хүрээнд нь төлөвлөгөөг нь баталж өгөөд тодорхой хэмжээний ажил хийгээд эргээд тайлан дээрээ бол түрүүн хэлсэн Антрэ нь бол өөрөө манай лицензийн талбай дээр ийм хэмжээний ажил хийгдсэн гэдэг бол тайлангаа гаргаж өгсөн гэж танд хэлэхэд. Баярлалаа.

О.Батнайрамдал: Хариулт хангалтгүй гэж үзсэн тул Зулпхар гишүүн нэмэлт нэг минут. Зулпхар гишүүний микрофон.

С.Зулпхар: Намчинсүрэн дарга би зүгээр ингэж асуугаад байна л даа. Яах вэ тэд нар тайлан гаргаад өгчихсөн юм байна. Тэр бол яах вэ цаасан дээр бичээд өгчихсөн юм байна шүү дээ. Тэгээд нэвтрэхийн тулд зөвшөөрөл авдаг юм уу? Ямар эрх зүйн орчин байдаг юм бэ? 2 жишээ нь компани хоорондоо жишээ нь тохироод л ингээд нэвтэрч болдог. Тэгээд ингээд тэрнийгээ зүгээр тайлан болгоод өгчихдөг ийм эрх зүйн орчин байгаа юм уу? Тэгээд та хэдэд тайлан өгсний дараа та хэд буцаад ямар захиргааны процесс хийсэн юм. Та хэд юу гэдэг жишээ нь магадгүй бичиг явуулсан юм. Нэвтэрсэн маань болжээ. Цааш нь нэвтрээрэй гэсэн юм уу, эс үгүй бол хууль зөрчжээ. Нэвтрэхийг чинь жишээ нь бид бол энийг бол зөвшөөрөхгүй шүү гэдэг ийм хариу өгсөн юм уу ямар учиртай юм бэ л гэж байгаа юм.

О.Батнайрамдал: 4 номерын микрофон.

Г.Намчинсүрэн: Гишүүний асуултад хариулъя. Ашигт малтмалын хуульд заасны дагуу бол тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уулын ажлын төлөвлөгөө тайланг батлах бол эрх бүхий байгууллага нь бол АМГТГ байгаа. Энэ хүрээндээ бол 2024 оны бол төлөвлөгөөг түрүүн ирүүлсэн байдаг. Тэрнийх нь дагуу баталсан. Эргээд бол хяналт тавих буюу тайланг нь авах нь бол мөн энэ байгууллага тэгэхээрээ тэр хүрээндээ тайланг нь аваад ажилласан байгаа.

Тэгэхээр өөрөөр хэлбэл төлөвлөгөөг нь бол баталж өгөөд хууль тогтоомжийнх нь дагуу тайланг нь аваад ингээд явсан байдаг.

О.Батнайрамдал: Зулпхар гишүүн хариулт хангалтгүй гэж үзэж байна. Дахиад нэмэлт нэг минут.

С.Зулпхар: Үгүй яах вэ би яг хариултаа нөгөө тэмдэглэлд үлдээх гээд байна л даа. Намчин дарга би ингэж ойлголоо. Би энэ нөгөө төлөөлж сууж байгаа түр хорооны гишүүний хувиар хэлж байгаа шүү. Ямар ч байсан манай эрх бүхий төрийн захиргааны байгууллага буюу Ашигт малтмалын Хэрэг эрхлэх газар нь 1 дүгээрт уулын ажлын төлөвлөгөөг авсан. Тэрэн дээр Онтрэ рүү жишээ нь нэвтрэнэ гэдэг төлөвлөгөө байсан. Тэрний дагуу бол Оюу Толгой компани нэвтрэлт хийгээд тэгээд тэр нь нэвтрэлт хийсэнтэй холбоотой тайлангаа буцаагаад хүргүүлчихсэн тэр тайланг нь хүлээгээд авчихсан байна гэдэг ийм хариулт авлаа зөв үү?

О.Батнайрамдал: 4 номерын микрофон.

Г.Намчинсүрэн: Таны ойлгож байгаа гишүүн ээ зөв өө. Зүгээр 2025 онд бол ямар нөхцөл бүрдчихсэн юм бэ гэхээр манайх бол Засгийн газрын хуралдаанаар энэ бүлэг ордын хил заагийг тогтоож өгөөд тэр дотор нь Антрэ орчихсон. Тэгэхээр үүнтэй холбоотой төрийн эзэмшлийн хувь хувиа тохиролцох бол эцсийн бол Засгийн газраас авч хэрэгжүүлэх хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн. Энэ хүрээндээ араас нь Монгол Улсын Ерөнхий сайдын захирамж гараад одоо ингээд 4 чиглэлээр ажиллаж байгаа. Энэ 4 ажил бол дөрвүүлээ хоорондоо уялдаа холбоотой гэдгийг бол би түрүүн хэлсэн. Батнайрамдал гишүүнд би дутуу буруу ойлголт өгчөв үү гэж ойлголоо.

Үндсэндээ бол Антрэ хойш нь тавиад байгаа юм байхгүй гишүүн ээ. Энийг бол аль алийг нь бүгдийг нь цугт нь ингээд л хооронд нь уялдаа холбоог нь хангаад л авч явах гээд л ингээд Засгийн газрын түвшинд бол ажиллаж байгаа гэдгийг хэлэх юм.

О.Батнайрамдал: Болормаа гишүүний микрофон.

Э.Болормаа: Бид нар энэ Монгол Улсын Ерөнхий сайдын 73 дугаартай захирамжийн хүрээнд ярьж байна гэж ойлгож байна. 2025 оны 8 сарын 22-ны өдөр байгуулсан энэ Онтрэ компанийн хувьцааны төрийн эзэмших хувь хэмжээг Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль, тогтоомжид нийцүүлэн тогтоох талаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, холбогдох бусад асуудлыг Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн асуудлыг ярилцаж байна аа. Энэ ажлын хэсгийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд ахалж байна.

Гишүүдэд нь Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд, ХЗДХ-ийн сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, ЗГХЭГ-ын дэд дарга, Татварын ерөнхий газрын дарга, АМГТГ-ын дарга ҮГА-ны дарга, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, нарийн бичгийн дарга Эрдэнэс Монгол Хязгаарлагдмал ХК-ийн гүйцэтгэх захирал гэсэн байна. Энэ бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 8 сарын 22-ны захирамжаас хойш яг хэдэн удаа хуралдсан бэ? Ирц ямар байсан? Протоколыг бид нарт хүлээлгэж өгнө үү гэж хүсье.

О.Батнайрамдал: Болормаа гишүүний асуултад хариулъя. 4 номерын микрофон.

Г.Намчинсүрэн: Болормаа гишүүний асуултад хариулъя аа. Энэ ажлын хэсэг дээр бол сайд ахалж байгаа. Та бүрэлдэхүүнийг нь уншаад өгчихлөө. Энэ ажлын хэсэг бол одоогоор хуралдаагүй байгаа.

О.Батнайрамдал: Болормаа гишүүний микрофон нэмэлт тодруулга.

Э.Болормаа: Энэ ажлын хэсэг хуралдаагүй байгаа учир өнөөдөр 9 сарын 24 буюу энэ ажлын хэсэг байгуулагдаад сар гарны хугацаа өнгөрсөн байна. Хуралдаагүй учир нэмж асуух асуулт алга. Би түр хорооныхоо даргаас л хүсэх юм уу даа. Дараагийн удаа энд яг хариуцаж байгаа хүмүүсийг нь дуудмаар байна аа. Би одоо энэ яамны хэдэн төрийн захиргааны албан хаагч нарыг ингээд буруутгаад суумааргүй байна. Энэ хүмүүсийн нэр энэ ажлын хэсэг дотор байхгүй. Тэгээд бүгдээрээ тал талаас нь асуугаад энэ хүмүүсийн буруу юм шиг. Гэхдээ энэ манлайллыг чинь энэ Засгийн газар үзүүлэх ёстой шүү дээ. Монгол Улсын ерөнхий сайд нь ингээд захирамж гаргачхаад үүрэг гаргаад тэгээд энийгээ бүүр 10 сард багтаагаад Засгийн газарт танилцуулах гэхихсэн байхад нэг ч хуралдаагүй байна аа.

Тэгэхээр дараагийн хурлууд дээр энэ сайд нараа өөрсдөө ирж энэ асуудлаа танилцуулмаар байна.

О.Батнайрамдал: Тэгээд Ерөнхий сайд нь захирамж гараад сар болсон тэгээд 1 ч хуралдаагүй. Тэгээд 10 сардаа багтааж Засгийн газарт танилцуулах юм байна шүү дээ. Та нар амжих уу? 10 сар гэдэг чинь сарын хугацаа л байгаа юм байна шүү дээ. Хагас хугацаа нь өнгөрчихсөн байна. Тэгээд дараа нь дэд ажлын хэсэг байгуулагдсан юм уу? Ард нь дэд ажлын хэсэг байгуулж болно. Тэгээд энд яг ажлын хэсэгт орсон хүн байна уу? Яг энэ ажлын хэсэгт орсон хүн байгаа юм уу? Энэ ажлын

хэсэгт орсон хүн байхгүй юм байна шүү дээ. Нарийн бичгийн дарга нь Эрдэнэс Монгол Хариуцлагатай ХК-ийн гүйцэтгэх захирал Наранцогт захирлын нарийн бичиг нь юм байна. Нарийн бичиг нь хаана байгаа юм?

Дарга нь байхгүй байхад ядаж нарийн бичиг нь байх хэрэгтэй шүү дээ. Гадаадад томилолттой ирээгүй гээд. Уг нь хамт явсан хүмүүс нь ирчихсэн байх юм. Тэгэхээр яг иймэрхүү байдлаар хандаж болохгүй л гэж байгаа юм. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаман дээр байгаа хамгийн том төслүүдийн нэг нь ер нь хамгийн том төсөл нь Оюу Толгой. Оюу Толгойн ТЭЗҮ, Оюу Толгойн уулын ажлын төлөвлөгөө. Оюу Толгойн хяналт. Оюу Толгой гэж ярьж байсан чинь Оюу Толгойг тойрсон Онтрэ компанийн эзэмшилд байгаа стратегийн ач холбогдол бүхий ордын хил заагт ордог лиценз гарч ирсэн. Уул нь энэ асуудал цоо шинэ биш. Гэхдээ 20 жил огт яригдахгүй хаягдаж ирснээс болоод өнөөдөр хэн хохирсон. Монгол Улс хохирсон шүү.

Тийм учраас энэ манай Хянан шалгах түр хорооны бүх гишүүд хэлээд байна. ОТ-той холбоотой асуудал дээр ямар нэгэн хойш нь тавих аргалах элсэлтгүй хийх эрх бид нарт байхгүй шүү. Бид нарт бүгдээрэнд нь байхгүй. Цаг хугацаатай нөгөө Онтрийн лиценз рүү ОТ-оос малталт орчихсон гээд сая Намчинсүрэн дарга Зулпхар гишүүний асуултад 2 3 ч удаа хариуллаа.

Олборлох гэж олборлоход бэлэн болчихсон байдаг. Гэтэл Монгол Улсын тэнд эрх ашиг. Монгол Улс Үндсэн хуулийн шаардлагаар Ашигт малтмалын тухай хуулийнхаа шаардлагаар хэдэн хувь эзэмших, яах ийх нь одоо хүртэл ойлгомжгүй байгаа. 20 жил ойлгомжгүй явж ирсэн. Энийг бүгдээрээ цэгцлэх ёстой. Энийг 3.5 сая иргэн бүгдээрээ чих тавин харж байгаа шүү. Энэ бол ганц яамны ч асуудал биш. Энэ бол Монгол Улсын Засгийн газар, Улсын Их Хуралтайгаа бүгдээрээ хамтарч л шийдэл гаргах ёстой зүйл. Тийм болохоор Хянан шалгах түр хороо 7 хоног болгон хуралдана аа.

Та бүхэн ирж энэ асуудлуудаа бүгдийг нь дахиж танилцуул. Өнөөдөр ингээд 2 яаман дээр дөнгөж ажлын хэсэг байгуулагдсан гэдэг агуулгаар ерөөсөө ямар ч танилцуулга явсангүй гэж ойлголоо шүү. Сая Намжилсүрэн даргын танилцуулсан презентаци дотор шинэ юм алга. Арга хэмжээ хийх гэж байгаа алхам ирээдүйн төлөвлөгөө. Ер нь энийг 10 сардаа багтаж Онтрэ дээр ямар шийдэл гаргаж Засгийн газар руу оруулах гэж байгаа шийдэл ерөөсөө байхгүй байна. Тэгэхээр дараагийн 7 хоног бид нарт цаг хугацаа байхгүй шүү дээ. Цаг хугацаа алдах тусам Болормаа гишүүн хэлсэн шүү дээ.

Бид нар өдөрт 10 тэрбум төгрөгийн зээлийн хүү Оюу Толгой, Рио Тинто төлснөөс болж Монгол Улсын ноогдол ашиг 37, 38 он гээд хэзээ нь мэдэгдэхгүй хугацаа л яриад суугаад байгаа байхгүй юу. Энийг наашлуулах боломж байна уу байна. Бид нарт олгосон гэрээний эрх байна уу? Байна.

Энэ дээр эс үйлдэхүй хийж болохгүй. Энэ дээр дахиад алдагдсан боломж яримааргүй байна. Тэр 2018 оны алдагдсан боломжийг яримааргүй байна. 2025 ондоо бид нар ийм өөрчлөлт гаргаад ахиц дэвшил гаргачихсан юм гэдэг ийм шийдэл яримаар байгаа байхгүй юу. Энэ 2 зүйл хоёулаа шийдэл шүү. Шийдэл боломжит шийдэл эрхээр эрх олгосон шийдэл. Тэгэхээр та бүхнийг гүйцэтгэх засаглал энэ дээр шийдэл гаргаад хамтдаа шийдэл гаргаад ирээч.

Хамтдаа алхъя л гээд байгаа шүү дээ. Тэгээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Танилцуулгыг сонссонд тооцлоо. Тэгээд дараагийн хуралдаан дараагийн яг энэ цаг мөчдөө болно. Яг өнөөдөр шийдлээ танилцуулаагүй бүх ажлын хэсгүүд дахиж Хянан шалгах түр хороонд ирж 7 хоногийн дотор шийдлээ танилцуулах ёстой. Тэгээд дараагийн хурлаар дахин уулзъя. Өнөөдрийн хурал өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА